

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН  
2021 ОНЫ 06 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2021.07.05

Сүхбаатар сум

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар:**

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2021 оны 6 дугаар сард 1 удаа хуралдаж 10 асуудал хэлэлцэн 10 тогтоол баталлаа. Үүнд:

1."Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2018-2020 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг "Хангалттай" гэж дүгнэлээ.

2."Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх аймгийн хөтөлбөр"-ийн 1 дүгээр үе шатны буюу 2017-2020 оны хэрэгжилтийн явц, үр дүнг "Хангалттай" гэж дүгнэв.

3."Залууст боломж хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн явц, үр дүнг "Хангалттай" гэж дүгнэлээ.

4.Үндсэн хөрөнгө актлаж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцээд зарим сум, байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, программ хангамж зэргийг акталж, данснаас хасахыг зөвшөөрөв.

5.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцээд зарим сум, байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, сэргээн засварлах боломжгүй болсон тээврийн хэрэгслүүдийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг тогтоов.

6.Сэлэнгэ аймгийг Хөдөлмөрийн баатар цолоор шагнуулахаар уламжлах тухай асуудлыг хэлэлцээд Улс эх орны эдийн засаг нийгмийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр тасралтгүй хангах үүргээ олон жил нэр төртэй хэрэгжүүлэн улсын жилийн нийт хэрэгцээний үр тарианы 60, төмсний 30, хүнсний ногооны 28 хувийг тогтмол хангаж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарыг хөгжлийн шинэ шатанд гаргах хөрс суурийг бүрдүүлэн тус салбарт хийгдэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийг эрчимжүүлэх үйлсэд Сэлэнгэ аймгийн иргэд, тариаланчид, малчдын оруулж байгаа хувь нэмрийг өндрөөр үнэлж Ардын хувьсгалын 100 жилийн ой, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг тохиолдуулан Сэлэнгэ аймгийг "Монгол Улсын Хөдөлмөрийн баатар" цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

7.Сэлэнгэ аймгийн Ахмадын хороог Алтан гадас одонгоор шагнуулах тухай асуудлыг хэлэлцээд Монгол төрийн ахмадуудын талаар явуулж буй бодлого, дэвшүүлж буй зорилт, Ахмад настны тухай хууль, ахмадуудын талаар гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэх үйлсэд ахмадууд, бүх шатны ахмадын хороо идэвх зүтгэлтэй ажиллаж үйл ажиллагаагаа тогтмолжуулан ажлын үр дүнгээрээ улсын хэмжээнд байнга эхний байруудыг эзэлж байгаа амжилтыг үнэлж Ардын хувьсгалын 100 жилийн ой, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 90 жилийн ой, Монголын Ахмадын байгууллагын 90 жилийн ойг тохиолдуулан Сэлэнгэ аймгийн Ахмадын хороог Алтан гадас одонгоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

8.Ардын хувьсгалын 100 жилийн ой, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг тохиолдуулан нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, төрийн захиргаа, хөдөө аж

ахуй, газар тариалан, спортын салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан Сэлэнгэ аймгийн харьяат зарим иргэдийг Монгол Улсын баатар, гавьяат цолоор шагнуулахаар уламжиллаа. Үүнд: Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цолоор Нацагийн Дэлгэрмөрөн, Жачины Янжив, Монгол Улсын Гавьяат хуульч цолоор Олдохын Буянтогтох, Гавьяат эдийн засагч цолоор Хандын Жавхлан, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цолоор Минээгийн Оюунтуяа, Монгол Улсын Гавьяат агрономич цолоор Ямаранзын Идэрнамнан, Хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цолоор Доржпаламын Арвин, Дэчингийн Пүрвээ, Баасанхүүгийн Сангижаргал, Мягмарын Шинэчулуун, Монгол Улсын Гавьяат тамирчин цолоор Гунаажавын Эрхэмбаяр, Монгол Улсын Гавьяат багш цолоор Рэгжийбуугийн Нямсүрэн, Нумчингийн Давдай, Урлагийн Гавьяат зүтгэлтэн цолоор Дугаржавын Нина нарыг шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

9. Ардын хувьсгалын 100 жилийн ой, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг тохиолдуулан нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, төрийн захиргаа, хөдөө аж ахуй, газар тариалан, спортын салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан Сэлэнгэ аймгийн харьяат зарим иргэдийг одон медалиар шагнуулахаар уламжиллаа. Сүхбаатарын одонгоор 2, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 23, Цэргийн гавьяаны улаан тугийн 1, Цэргийн гавьяаны одонгоор 5, Алтан гадас одонгоор 61, Хөдөлмөрийн хүндэт медалиар 196, Цэргийн хүндэт медалиар 2 хүнийг шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

#### **Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2021 оны хагас жилийн тайланг Монгол Улсын Засгийн газарт хүргүүлсэн. Сэлэнгэ аймагт хамааралтай хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 227 заалтын хэрэгжилтийг холбогдох хэлтэс, албадаас татан авч нэгтгэн боловсруулсан. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт 85.64 хувийн гүйцэтгэлтэй байна.

Япон Улсын Шизоука мужийн газар тариалангийн хэлтээс Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай цахим хурал хийлээ. Тус хурлаар -30 хэм хүртэл тэсвэртэй майхангийн материалтай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн хадгалах агуулахын бизнесийг Монгол Улсад нутагшуулах талаар харилцан санал солилцлоо. Тухайн агуулах нь ердийн байнгын агуулахаас хямд, богино хугацаанд суурилуулах боломжтой бөгөөд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанарыг алдагдуулахгүйгээр хадгалах онцлогтой юм. Тухайн бүтээгдэхүүнийг суурилуулахын тулд Сэлэнгэ аймагт газар дээр нь очиж судлахаас өмнө урьдчилсан байдлаар мэдээлэл цуглуулах зорилгоор энэ удаагийн уулзалтыг зохион байгууллаа. “Санамж бичиг”-ийн хүрээнд 2021 онд хийж хэрэгжүүлэх ажлын ерөнхий төлөвлөгөөний талаар 2 удаа цахим уулзалт хийж харилцан санал солилцлоо. Үүнд:

1. 2021 онд Газар тариалангийн мэргэжилтний сургалт, зохион байгуулах талаар
2. Газар тариалангийн чиглэлээр харилцан туршлага, мэдээлэл солилцох

Гааль, эрүүл мэнд, спортын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан Сэлэнгэ аймгийн харьяат зарим хүмүүсийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн одон медалиар, мөн салбарын шагналаар шагнагдсан. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 2, Цэргийн гавьяаны одонгоор 1, Алтан гадас одонгоор 12, Хөдөлмөрийн хүндэт медалиар 1, Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтнаар 1, Тэргүүний барилгачнаар 2, Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Хүндэт тэмдгээр 2 тус тус шагнагдсан.

#### **Аймгийн Онцгой комиссын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабаас дэлхийн дахинд тархаад буй коронавирус /Ковид-19/-ын халдварын тохиолдол гарч, халдварлах эрсдэл бий болсонтой холбоотойгоор урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр Онцгой комиссын орлогч, Шуурхай штабын дарга, дэд хурандаа Г.Галбадрахаар ахлуулсан - **9**, Цагдаагийн газар - **4**, Мэргэжлийн хяналтын газар - **4**, Эрүүл мэндийн газар - **1**, Газар, хэлтэс, агентлагийн дарга - **1** /ерөнхий жижүүр/, Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газраас - **2** нийт **21** албан хаагч өглөөний **09:00** цагаас оройн **21:00** цаг хүртэл ажиллан дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Хилийн боомтын талаар авах арга хэмжээний тухай” 77, “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 78, “Бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлэх тухай” 91, “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 104, “Журмын хавсралтыг өөрчлөн батлах тухай” 105 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын “Шуурхай штабыг шинэчлэн байгуулах тухай” 22, “Түр журам заавар батлах тухай” 31, “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам” 37 дугаар тушаал, Улсын Онцгой комиссын 2021 оны “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 02, “Коронавируст халдвар /ковид-19/-ын тархалт эрс нэмэгдсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 03, “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр тогтоол, “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын тархалтыг хумих хариу арга хэмжээг сайжруулах, халдвар хамгааллын дэглэм, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай” 03 дугаар албан даалгавар, хуралдааны тэмдэглэл, тушаал шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр Аймгийн Онцгой комисс **5** удаа хуралдан **9** асуудлыг хэлэлцэж **46** асуудлыг шийдвэрлэн аймгийн Засаг даргын захирамж **1**, тогтоол **2**, хурлын тэмдэглэл **5**-г гарган албажуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын тогтоол, тушаал шийдвэрийн дагуу аймгийн Онцгой комиссын хуралдаанаас гарсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах чиглэлээр сум, агентлаг, аж ахуй, нэгж, байгууллагуудад нийт **72** албан тоотоор үүрэг чиглэл, зөвлөмж, шаардлага, хүсэлтийг хүргүүлж, **209** албан бичгийн бүртгэл хөтлөн хүлээн авч, албан бичгээр ирсэн тайлан мэдээг боловсруулан нэгтгэж, өдөр тутмын нөхцөл байдлын мэдээнд тусгуулах, ирсэн хүсэлтийг холбогдох ажлын хэсэгт хүргэн шийдвэрлүүлэн, аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт Засгийн газрын 2021 оны 91, 104 дүгээр тогтоолын дагуу Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 00:00 цагаас 05 дугаар сарын 08-ны өдрийн 00:06 цаг хүртэл сунган ажиллаж байна.

Шуурхай штабын **70363684**, **70360119** дугаарын утсанд **1260** мэдээлэл, цахим хаягаар **215** албан бичиг, гар өргөдөл **10** нийт **1485** мэдээллийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас болон Онцгой байдлын газрын цахим пэйж хуудсанд Онцгой байдлын газар, Дэлхийн Зөн Монгол Олон улсын байгуулагтай хамтран “Яагаад амны хаалт зүүх ёстой вэ?”, “Гараа яагаад угаах ёстой вэ?”, “Хамтын хүчээр халдвараас сэргийлье”, “Ковидгүй Сэлэнгийн төлөө” “ Жирэмсэн

болон хөхүүл эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулсан сэрэмжлүүлэг шторк **5-ыг** бэлтгэн, **80** удаа мэдээ, мэдээлэл байршуулж **105446** хандалтыг авч Онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Р.Мөнхбат цаг үеийн нөхцөл байдал, хариу арга хэмжээний талаар цахим мэдээллийн хэрэгслээр 2 удаа өгч ажилласан.

Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран 2021 оны 05 сарын 01-ний өдрөөс эхлэн өдөрт **2** удаагийн давтамжтайгаар 12:00,17:00 цагуудад нөхцөл байдлын талаарх мэдээлэл бэлтгэн аймгийн Засаг даргын Тамгын газраас “Сэлэнгэ аймаг АЗДТГ”, “Сэлэнгэ Цахим телевиз” цахим хуудас, Зиндаа.мн сайт, Улс төрч.мн сайт, Сүхбаатар сум дахь лед дэлгэц, орон нутгийн “Миний Монгол ТВ”, “Таны Сэлэнгэ ТВ” мөн МҮОНТ-ийн ММ агентлаг, Өлзий телевиз, Монцамэ агентлаг зэрэг мэдээллийн сувгуудаар мэдээ, мэдээллийг дамжуулан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Онцгой комиссын шуурхай штаб, Онцгой байдлын ерөнхий газарт тухай бүр мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нэгдүгээр тун **40349**, хоёрдугаар тун **36820** хийгдээд байна. Аймгийн хэмжээнд 06 сарын 22-ны өдрийн байдлаар **961** тохиолдол бүртгэгдэж үүнээс эдгэрсэн **575**, эмчлэгдэж байгаа **370** хүн байна. Үүнд:

№	Сум, Тосгон	Батлагдсан тохиолдлын тоо			Нийт
		Сүүлийн 24 цагт /2 дахь давлагаанд тоон орсон/	Эхний давлагаа	2 дахь давлагаа	
1	Сүхбаатар	4	211	120	331
2	Алтанбулаг	1	2	23	25
3	Шаамар			1	1
4	Дулаанхаан тосгон			3	3
5	Зүүнбүрэн			6	6
6	Цагааннуур	1		4	4
7	Түшиг	1		90	90
8	Жавхлант			13	13
9	Хушаат	1		5	5
10	Ерөө	1		15	15
11	Бугант тосгон			12	12
12	Хүдэр	1		66	66
13	Мандал	7	4	180	184
14	Хэрх тосгон	14		86	86
15	Түнхэл тосгон			1	1
16	Баянгол	2		43	43
17	Сайхан			15	15
18	Номгон тосгон			4	4
19	Орхон			2	2
20	Сант				
21	Баруунбүрэн	6		42	42
22	Орхонтуул			5	5
23	Рашаант тосгон	1		3	3
<b>Нийт</b>		<b>43</b>	<b>217</b>	<b>744</b>	<b>961</b>

Сэлэнгэ аймгийн хэмжээнд эхний давлагаанд 217, 2 дахь давлагаанд 744 тохиолдол тус тус бүртгэгдэж нийт 961 тохиолдол батлагдсан тохиолдлоор бүртгэгдсэн.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд нийт батлагдсан 961 иргэний тархвар зүйн зураглал үйлдэн эх уурхайг тогтоох зорилгоор Шуурхай хариу арга хэмжээний баг ажиллаж



байна.

Сэлэнгэ аймагт **961** тохиолдол батлагдсанаас ойрын хавьтал **4481**, дам хавьтал **4187**, нийт **8668** ойрын болон дам хавьтал тогтоогдож байна.

Шинжилгээ авах **18** багт **25** эмч, эмнэлгийн ажилтан тогтмол ажиллаж түргэвчилсэн оношлуурын шинжилгээнд **81538** ПГУ **70804** нийт **152342** иргэнийг хамруулсан.

Аймгийн хэмжээнд бэлтгэсэн тусгаарлан ажиглах байрны тоо өссөн дүнгээр **997**, орны тоо **8125**, ашиглаж буй тусгаарлах байрны тоо **59**, орны тоо **254** байна.

Аймгийн хэмжээнд /өссөн дүнгээр/ **10517** өрхийн **15439** том хүн, **0-16** насны **7343** хүүхэд, хамт тусгаарлагдсан **29346** нийт **51959** иргэнийг гэрийн тусгаарлан ажиглалтад оруулж ажилласан.

Энэ хугацаанд нийт **36** хяналтын цэгт **378** Цагдаагийн газрын албан хаагч **120** тээврийн хэрэгсэлтэй, Онцгой байдлын газрын **630** алба хаагч, Эрүүл мэндийн байгууллагын **420**, Мэргэжлийн хяналтын газрын **110** бусад төрийн байгууллагуудын **798** нийт **2336** албан хаагч үүрэг гүйцэтгэсэн.

Улаанбаатар хот бусад аймаг орон нутгаас Сэлэнгэ аймгийн сумд руу орох чиглэлд **8823** тээврийн хэрэгсэлтэй **15774** том хүн, **0-16** насны **1930** хүүхэд нийт **17704** иргэн, Улаанбаатар хот бусад аймаг орон нутаг руу гарах чиглэлд **4702** тээврийн хэрэгслээр **10114** том хүн, **0-16** насны **693** хүүхэд нийт **10807** иргэнийг түргэвчилсэн оношлуурын болон ПГУ-ийн шинжилгээний хариу, асуумж, нэвтрэх зөвшөөрлийг үндэслэн нэвтрүүлсэн.

Цагдаагийн газраас нийт **17** гомдол мэдээллийг хүлээн авч **6** хэрэг дээр зөрчлийн хэрэг нээж, **6** хэрэг ажиллагаанд, **2** хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, **2** хэргийг татгалзаж, **1** иргэнийг **7** хоногоор баривчлах арга хэмжээ авч ажилласан байна.

Улсын Онцгой комиссын тогтоол, шийдвэрийн дагуу Монгол Улсын хилээр орох чиглэлд **9** орны **1094** зорчигч, **1601** тээврийн хэрэгсэл, гарах чиглэлд **9** орны **1126** зорчигч, **1450** тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу шалган нэвтрүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 18 дугаар тушаалаар батлагдсан “Коронавируст халдвараас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”, аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах зорилгоор МХЕГ-ын 01/48 тоот удирдамжийн дагуу үсчин, гоо сайхан, хумс заслын **64**, нийтийн халуун ус, саун, бассейн **10**, зочид буудал, дэн буудал **8**, нийтийн тээврийн **15**, хүнсний үйлдвэр **1**, хүнсний худалдаа **175**, нийтийн хоол үйлдвэрлэл, хүргэлтийн үйлчилгээний **14**, хүнсний бус бараа бүтээгдэхүүний **61** нийт **348** объектын үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлагад зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ.

2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 20 цагийн байдлаар нийт өссөн дүнгээр Сэлэнгэ аймгийн хэмжээнд коронавируст халдвар батлагдсанаас хойш **ПГУ- 58748**, **түргэвчилсэн- 65684** нийт **124,432** иргэнийг шинжилгээнд хамруулсан байна.

Аймгийн хэмжээнд 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрүүдэд ариутгал халдваргүйжүүлэлтийг ОБГ, МЭГ, ЗӨСТ, “Сэлэнгэ үйлчилгээ” ӨНӨААТҮГ, сумдын эрүүл мэндийн төв, мал эмнэлгийн төвүүд хамтран **2107** объектын **1082061,2** метр квадрат талбайд Мэргэжлийн хяналтын газрын хяналтан дор ариутгал халдваргүйжүүлэлтийн ажил зохион байгуулан ажилласан.

#### **Аймгийн сонгуулийн хорооны үйл ажиллагааны талаар:**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх, ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн 17 сумаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хэсэгт байгуулах тухай тогтоолыг авч сонгуулийн хэсэгт хамаарах нутаг дэвсгэр, санал авах байр гудамж, бүрэн орсон эсэх, нэг хэсэгт байх сонгуулийн насны иргэдийн тооны дээд, доод хязгаарт хяналт хийж 17 сумын 56 санал авах байр, хаягийн мэдээллийг шивж баталгаажуулснаар аймгийн хэмжээнд Ерөнхийлөгчийн сонгуулийн 56 хэсгийн хороо байгуулагдсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд 17 сумын 56 хэсэгт аймаг, сумын сонгуулийн хороо, хэсгийн хороонд нийт 675 төрийн албан хаагч, Сонгуулийн санал авах байрны хамгаалалтад 112 цагдаагийн алба хаагч, 56 хэсгийн хороо тус бүрд 1, аймгийн Нэгдсэн эмнэлэг, тусгаарлах байранд 12 буюу нийт 68 эмч эмнэлгийн ажилтан, Онцгой байдлын газрын 45 алба хаагч, Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн 67 ажилтан, Мэдээлэл, технологийн 79 даамал, Зоонозын өвчин судлалын төвийн 5, Мэргэжлийн хяналтын газрын 5 албан хаагч буюу нийтдээ 1056 ажилтан тус тус томилогдон ажиллалаа. Сэлэнгэ аймгийн хэмжээнд 56 хэсгийн хороонд 71 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг дайчлан ажиллуулж сонгогчдын халдвар, хамгааллын дэглэмийг хууль, дүрэм журам, зааврын дагуу хийж гүйцэтгэн, сонгогчийн биеийн халууныг хэмжиж, маскыг тогтмол солиулж, гарын халдваргүйтгэлийг хийлгэж, санал авах байрны цэвэрлэгээ үйлчилгээ, агааржуулалтад хяналт тавьж, халдваргүйтгэлийг 2 цаг тутамд хийж ажиллуулсан.

Санал авах үйл ажиллагаа зөөврийн битүүмжилсэн хайрцагар 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 9.00 цагаас эхлэн хэвийн явагдсан зөөврийн хайрцагар Сүхбаатар суманд санал өгөх ковидын эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлж байгаа

болон ажил үүргээ гүйцэтгэж байгаа сонгогч, тусгаарлалтын 2 байр, гэрийн тусгаарлалтад байгаа сонгогчоос санал авах үйл ажиллагааг Сонгуулийн хэсгийн хороо, Зоонозын өвчин судлалын төв, Цагдаагийн байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд нийт 596 хүн зөөврийн хайрцгаар санал өгөхөөс энгийн иргэн 320, коронавирусын улмаас эмчлүүлж байгаа 4, тусгаарлах байранд байгаа 14, тусгаарлах байранд ажиллаж байгаа 20, гэрийн ажиглалтад 213, нийт 571 хүнээс авч 95.8 хувьтай явагдаж дууслаа.

Энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийг ажиглахаар МАН-аас 159, АН-аас 66, Зөв хүн Электорат эвслээс 40 хүний хүсэлт ирүүлсний дагуу нийт 265 ажиглагч үнэмлэхээ авч ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хороо нь удирдлага, зохион байгуулалт, цаг үеийн ажил арга хэмжээ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажил болон зөөврийн хайрцгаар болон гэрийн тусгаарлалтад байгаа иргэдээс санал авах, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 152 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үед коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журам”-ын хэрэгжилтийг хангах, бэлтгэл ажлыг хэрхэн хангасныг удирдамжийн дагуу шалган танилцаж, зөвлөмж, чиглэл өгөх зэргээр Монгол Улсын Онцгой байдал, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Зоонозын өвчин судлалын төв, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мэргэжлийн хяналтын газар зэрэг байгууллагуудыг оролцуулан өргөтгөсөн байдлаар 3 удаа, буюу нийтдээ 8 удаа хуралдаж, 4 тогтоол, 5 захирамжийг гаргаж, сумдын Сонгуулийн хороо, хэсгийн хороодтой цахимаар 6 удаа хуралдаж үүрэг, зөвлөмж чиглэл өгөн ажиллалаа.

Аймгийн хэмжээнд сонгогчийн нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт 71265 сонгогч, үүнээс үндсэн 70338 сонгогч бүртгэлтэй байснаас хурууны хээгээр 35961 сонгогч буюу 51.13 хувь нь саналаа өгсөн. Үүнээс 25149 буюу 69.93 хувь нь Ухнаагийн Хүрэлсүхийн төлөө, 2401 буюу 6.68 хувь нь Содномзундуйн Эрдэнийн төлөө, 5901 буюу 16.41 хувь нь Дангаасүрэнгийн Энхбатын төлөө тус тус саналаа өгч, ээлжит сонгуулийн үйл ажиллагаа хэвийн явагдлаа.

Санал авах ажиллагаа дууссаны дараа сумын сонгуулийн хороо МАН, АН, “Зөв хүн электорат” эвслийн ажиглагч нарыг байлцуулан бүх хэсгийн хороодод хяналтын тооллого хийлгүүлээ. Сонгуулийн ерөнхий хорооны 22 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан журмыг баримтлан тооллогын ажиллагааг гүйцэтгэж, санал тоолох төхөөрөмжид уншигдсан саналын хуудсыг гар аргаар нэг бүрчлэн тоолоход хяналтын тооллого хийсэн бүх хэсгүүдэд хяналтын тооллогын дүн санал тоолох төхөөрөмжийн дүнтэй таарсан бөгөөд хяналтын тооллогын үйл ажиллагааг Сэлэнгэ аймгийн 56 хэсгийн хороонд Сонгуулийн ерөнхий хорооноос олгосон хяналтын камерт буулгасан болно.

#### **Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:**

2021 оны 06-р сарын 24-ний өдрийн 21 цаг 45 минутад /Сайхан сумаас 54 км, аймгийн төвөөс 214 км, Орхонтуул сумаас 6 км, Дархан-Уул аймгаас 114 км, Орхон аймгаас 160 км/-т Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын 1-р баг Бэлэндалай өртөөний 76 дугаар км-ийн 10 дугаар зуутаг ОХУ-с Орхон аймгийн чиглэлд явж байсан 4002 элчит тэрэгтэй 3202 галт тэрэгний 23 цувааны сүүлийн 6 вагон тасарч 9-р вагоноос 17-р вагон хүртэл дизель түлштэй 7 вагон, техникийн масло ачсан 1 вагон, элс ачсан 1 вагон, нийт 9 вагон унаж, таг болон илүүдлийн хавхлагаар дизель түлш, масло асгарч байгаа тухай дуудлагыг аймгийн Онцгой байдлын газарт ирүүлсэн.

2021.06.25-ны өдрийн 00:55 цагт Улаанбаатар төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын Онцгой байдлын албаны тээврийн албаны дарга Б.Гантөмөрөөр ахлуулсан 46 алба хаагч галын, сэргээн босгох крантай 6 галт тэрэг Улаанбаатар хотоос гарч 12:20 цагт ирж Улаанбаатар Төмөр замын зам, эрчим хүчний засварын ангийн 50 ажилтан, 8 техник хэрэгсэлтэй, нийт 60 хүн, 10 автомашин, 6 вагонтойгоор аврах ажиллагааг зохион байгуулж байна. 06 сарын 27-ны 00:00 цагт 1 тн керосин сэлгэн ачих ажил дуусаж гал түймэр унтраах, аврах 61 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн Улаанбаатар төмөр замын гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, хошууч М.Мөнгөнхүлэгт хүлээлгэн өгч 00:16 цагт ангийн байрлал руу буцаж, 02:50 цагт ангийн байрлалд ирсэн.

2021 оны 06 дугаар сарын 12-14 ний өдрүүдэд Хараа, Ерөө, Орхон голын эрэг дагуу айл өрхүүд рүү үер бууж усанд боогдсон дуудлагаар нийт 30 өрхийн 65 том хүн, 35 хүүхэд, 28 гэр, мал амьтныг үерийн уснаас гарган нүүлгэн шилжүүлж ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн санал авах байр, хэсгийн хороодын барилга байгууламжид Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамж, аймгийн Сонгуулийн хорооноос гаргасан удирдамжийн дагуу Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтран 17 сум, 6 тосгоны нийт 56 хэсгийн хороо, санал авах байруудад хяналт шалгалт зохион байгуулан халдвар хамгааллын урсгал зөрчигдсөн, цахилгааны дотор хэлхээ гэмтэлтэй 74 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн 17 дүгнэлтийг аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлсэн.

Мөн аймгийн Онцгой комиссоос Сонгуулийн хороонд коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, санал авах байр, хэсгийн хороодын барилга байгууламжийн гал түймрийн аюулгүй байдлыг хангуулах, гол мөрөн гаталж сонгуульд оролцох иргэдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2021 оны 06 сарын 07-ны өдрийн 5735 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн.

Тайлант үед аймгийн шуурхай штабын мэдээг нэгтгэн Улсын онцгой комиссын шуурхай штаб, Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газрын шуурхай штаб, хойд бүсийн төвд өдөр бүр 08:00, 11:00, 16:00, 18:00, 22:00 цагуудад хүргүүлж нийт 31 удаа явуулж ажилласан байна.

**Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар:** Аймгийн хэмжээнд 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар голомтын халдваргүйжүүлэлтийг 2817 объектод 1038546.5 метр квадрат талбайд ЗӨСТ, Мандал сумын нэгдсэн эмнэлэг голомтын халдваргүйжүүлэлтийг хийхэд МХГ-аас хяналт тавьж ажиллаж, урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн зам талбайд 364769 метр квадрат талбайд аймгийн Онцгой байдлын газар, байрны орц, хонгил, гадна талбайд 284584.5 метр квадрат талбайд аймгийн Мал эмнэлгийн газар, ЗӨСТ-ийн халдваргүйжүүлэлтийн хамтарсан баг, аймгийн Засаг даргын хүнсний худалдааны газруудад 150002 метр квадрат талбайд МЭГ-ын халдваргүйтгэлийн баг, Онцгой байдлын газар, ЗӨСТ-ийн халдваргүйтгэлийн баг халдваргүйжүүлэлтийг хийж, халдваргүйжүүлэлт хийх үеийн халдвар хамгааллын дэглэм, халдваргүйжүүлэлтийн уусмалын концентрацыг газар дээр нь тодорхойлж хяналт тавьж ажилласан.

Коронавируст халдварын батлагдсан тохиолдлыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн ковидын тасагт шилжүүлж тусгаарлан эмчлэх боломжгүй эрсдэлт бүлгийн иргэдийг нэмэлтээр Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасагт эмчилж эхлэхтэй холбогдуулан ковидын тасгийн бэлэн байдалд дэмжлэгт хяналтыг 2021 оны 06 дугаар



сарын 21-ний өдөр хийж эмч, эмнэлгийн ажиллагсдын халдвар хамгааллын дэглэм, анхаарах асуудлын хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газар, Зооноз өвчин судлалын төвтэй хамтран мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулан ажиллалаа.

2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар үсчин, гоо сайхан, хумс заслын 131, нийтийн халуун ус, саун, бассейн 22, зочид буудал, дэн буудал 21, биеийн тамир, спорт, чийрэгжүүлэх, бялдаржуулах төв 8, соёл урлаг, үзвэр үйлчилгээ 3, сүм хийд шашны байгууллага 8, нийтийн тээврийн 28, ерөнхий боловсролын сургууль 33, сургуулийн өмнөх боловсролын байгууллага 46, өдөр өнжүүлэх, хүүхэд харах үйлчилгээ 6, хүнсний үйлдвэр 6, хүнсний худалдаа 510, нийтийн хоол үйлдвэрлэл, хүргэлтийн үйлчилгээний 72, хүнсний бус бараа бүтээгдэхүүний 243 нийт 1137 объектын үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлагад зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ.

Зөвлөн туслах үйлчилгээний явцад 4853 зөрчлийг илрүүлж 1757 буюу 36.2%-ийг газар дээр нь арилгуулж, зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор Улсын онцгой комиссын даргын 2021 оны 41 дугаар тушаалаар батлагдсан “Коронавируст халдвараас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ын тусгай нөхцөл шаардлага, улсын байцаагчийн зөвлөмж, аймгийн Онцгой комиссын 08 дугаар тогтоол, сэрэмжлүүлгийг өгч, улсын байцаагчийн 14 төрлийн зөвлөмжийг 1137 объектод хүргүүлж, аж ахуйн нэгж, байгууллагын 1203 иргэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллалаа.

#### **Стандартчилал, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:**

Мандал, Баянгол, Хүдэр, Сүхбаатар, Алтанбулаг, Сайхан, Цагааннуур, Баруунбүрэн, Түшиг сумын 47 аж ахуйн нэгжийн 48 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж, МУ-ын “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ, Ерөнхий шаардлага MNS 5021-1:2019”, “Хоолны газрын үйлчилгээ, Ерөнхий шаардлага MNS 4946:2019”, “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ, Дэн буудалд тавих шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлага хангасан 45 иргэн, аж ахуйн нэгжийн 46 үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээ олгосон.

Стандарт, мэдээллийн салбар сангаас 6 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 13 нэрийн 16 стандартын талаар мэдээлэл арга зүй зөвлөмж өгч, 4 аж ахуй нэгж, байгууллагад 4 нэрийн 6 стандартын борлуулалт хийсэн.

Шинээр болон шинэчлэн боловсруулж байгаа, нэмэлт өөрчлөлт оруулахаар санал авч буй стандартын төслийн талаарх мэдээллийг байгууллагын фэйсбүүк болон цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчлах, мэдээлэх ажлыг тогтмол хэрэгжүүлж байна.

Хилийн мэргэжлийн хяналтын албатай “Хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын 2021 оны гэрээ”-г байгуулав.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр: “НИК”, “ДАШВААНЖИЛ” ХХК-ий инженер, техникийн ажилтнуудтай хамтран аймгийн 15 суманд байрлах шатахуун түгээх станц, АХЦС-уудыг шалган баталгаажуулахаар ажиллаж байна.

Механикийн хэмжлийн төрлөөр: Худалдаа үйлчилгээнд ашиглагдаж буй 11 ширхэг жинг шалган баталгаажууллаа. “Буянт Рашаан”, “Ахмадын эмийн сан”-уудын 2 ширхэг электрон жинд шалгалт тохируулга хийсэн байна.

Дулаан даралтын хэмжлийн төрлөөр: 14 ширхэг манометр шалган баталгаажуулав.

Цахилгаан хэмжлийн төрлөөр: Айл өрх, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй 1 ба 3 фазын 20 ширхэг цахилгааныг тоолуурыг шалган баталгаажууллаа.

**Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

Өнгөрсөн сард 718 баримтаар 8,346,131.3 мянган төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн 05 сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж ажиллалаа.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн цахим хуудас, шилэн данс болон ил тод самбарт байршуулсан.

ТЕЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар гарсан төсвийн гүйцэтгэл болон орон тооны тайлбарыг Сангийн яамд явуулсан.

ТЕЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар аудитын газраас өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтийг хангах зорилгоор сумдын засаг дарга болон байгууллагуудын дарга, ОНӨААТҮГ-ын дарга нарт 01/534, 01/535/, 01/536 албан тоотоор үүрэг чиглэл хүргүүлсэн.

**1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
<b>1. Орон нутгийн төсвийн нийт орлого</b>		<b>50,890,569.4</b>	<b>49,680,838.1</b>	<b>97.6</b>
1.1	<b>Орон нутгийн төсвийн орлого</b>	<b>11,287,442.2</b>	<b>12,885,698.6</b>	<b>114.2</b>
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	7,486,584.6	7,347,633.7	98.1
	Сумдын төсвийн орлого	3,800,857.6	5,538,064.9	145.7
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	1,902,189.0	1,902,189.0	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	24,718,697.2	24,718,697.2	100.0
1.4	Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлэг	273,482.0	170,235.4	62.2
1.5	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	3,041,932.8	2,337,352.3	76.8
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	5,688,177.4	5,688,177.4	100.0
1.7	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	748,477.5	288,544.7	38.6
1.8	Төсөвт байгууллагын өөрийн орлого	296,772.2	1,173,794.2	395.5
1.9	ОНХС-д хандив	1,710,000.0		-
1.10	Сум хөгжүүлэх сан /орлого/	1,223,399.1	516,149.2	42.2
<b>2. Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>		<b>50,890,569.4</b>	<b>34,913,381.4</b>	<b>68.6</b>
2.1	<b>Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>	<b>50,890,569.4</b>	<b>34,913,381.4</b>	<b>68.6</b>
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	12,234,851.0	6,760,143.7	55.3
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	2,753,267.9	146,532.4	5.3
	Сумдын сум хөгжүүлэх сан			
	<b>Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага</b>	<b>6,936,809.0</b>	<b>3,897,566.2</b>	<b>56.2</b>
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	300,625.0		
	Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт			
Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	2,561,317.1	571,731.4	22.3	

	Халамжийн сан	82,034.6	15,600.0	19.0
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	3,119,425.0	2,671,870.9	85.7
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	873,407.3	638,363.8	73.1
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	28,496,095.8	23,721,505.6	83.2
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	469,545.7	387,633.5	82.6
<b>3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг</b>		<b>33,456,022.9</b>	<b>32,576,163.9</b>	<b>97.4</b>
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	5,695,392.9	5,520,114.4	96.9
3.2	<b>Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг</b>	<b>1,812,965.1</b>	<b>908,704.0</b>	<b>50.1</b>
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	<b>58,892.5</b>	<b>58,892.5</b>	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд			
	Хөрөнгө оруулалтын зардалд	1,754,072.6	849,811.5	
3.3	<b>Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг</b>	<b>1,228,967.7</b>	<b>1,428,648.3</b>	<b>116.2</b>
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	<b>1,051,317.1</b>	<b>1,051,317.1</b>	100.0
	Усны татаас	156,000.0	156,000.0	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	21,650.6	21,650.6	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	24,308,984.3	24,308,984.3	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	409,712.9	409,712.9	100.0
3.6	<b>Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/</b>	<b>24,718,697.2</b>	<b>24,718,697.2</b>	<b>100.0</b>
	- Ерөнхий боловсролын сургууль	13,015,857.4	13,015,857.4	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	7,342,754.4	7,342,754.4	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	3,887,022.0	3,887,022.0	100.0
	- Газрын кадастрын байгууллага	243,091.6	243,091.6	100.0
	- Хүүхдийн байгууллага	229,971.8	229,971.8	100.0
<b>4. Тусгай сангуудын зарлага</b>		<b>1,223,399.1</b>	<b>516,149.2</b>	<b>42.2</b>
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	1,223,399.1	516,149.2	42.2

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2020 05- сар	2021 05- сар	2021-05 2020-05 Х/төгрөгөөр/
<b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>				
<b>1</b>	<b>ТАЛХ, ГУРИЛ, БУДАА</b>			
	Гурил /савласан, кг/	1 200	1 300	108.3
	Талх /орон нутгийн, ш/	1 300	1 300	100.0
	Нарийн боов /кг/	2 500	2 600	104.0
	Будаа /кг/	2 500	2 600	104.0

	Элсэн чихэр /кг/	2 000	2 500	125.0
<b>2</b>	<b>МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН</b>			
	Хонины мах /кг/	8 500	11 000	129.4
	Үхрийн мах /кг/	9 500	12 500	131.6
	Адууны мах /кг/	7500	9 000	120.0
	Ямааны мах /кг/	7800	10 000	128.2
	Дотор мах, цувдай /цусгүй/	5000	6 000	120.0
	Хиам /чанасан, кг/	11 000	11 000	100.0
<b>3</b>	<b>СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ</b>			
	Сүү /задгай, л/	1 600	1 700	106.3
	Сүү / савласан, л/	3 200	3300	103.1
	Тараг /задгай, л/	1 900	2 000	105.3
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	16 000	20 000	125.0
	Айраг /л/	4 000	5 000	125.0
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	500	142.9
<b>4</b>	<b>БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС</b>			
	Ургамлын тос /л/	4 500	5 500	122.2
	Өөхөн тос /кг/	2 500	4 000	160.0
	Шар тос /кг/	15 000	24 500	163.3
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
<b>5</b>	<b>ХҮНСНИЙ НОГОО</b>			
	Төмс /кг/	1 100	1 200	109.1
	Лууван /кг/	1200	1 200	100.0
	Манжин /кг/	2000	2500	125.0
	Байцаа /кг/	1200	2500	208.3
	Сонгино /кг/	2000	2000	100.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	4 500	4 500	100.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	3000	3 200	106.7
<b>7</b>	<b>ШАТАХУУН</b>			
	Бензин А - 80	1 390	1 440	103.6
	Бензин А - 92	1490	1470	98.7
	Дизелийн түлш	2170	2290	105.5

### **Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар зарлигаар батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журмын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2021 оны эхний хагас жилийн тайланг аймгийн хэмжээнд нэгтгэн 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 01/641 албан тоотоор тайланг хүргүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх аймгийн хөтөлбөр”-ийн 1-р үе шатны буюу /2017-2020/ оны хэрэгжилтийн явц, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн “ХАНГАЛТТАЙ” үнэлэгдлээ.

Сургалт сурталчилгааны ажлын хүрээнд Төрийн албан хаагчийн ёс зүй, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай

хууль, Замын хөдөлгөөний дүрэм, Ан амьтны тухай хуулиудаар сургалт, сурталчилгааг цахимаар зохион байгуулж, цахим хуудсанд байршуулан 5800 гаруй иргэдэд түгээж ажиллалаа.

**Цагдаагийн газар:** Аймгийн хэмжээнд 2021 оны 06 сард 173 холбогдогчтой 788.2 сая төгрөгийн хохиролтой 271 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 47 хэргээр буюу 14.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 38.9 хувьтай байгаа нь өмнө оныхоос 7.9 хувиар буурсан байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 6 дугаар сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 105, лавлагаа 14 олгож үйлчиллээ.

2 дугаар сард иргэний бүртгэлийн талаар:

- Төрсний бүртгэл – 216 /эрэгтэй-111, эмэгтэй-105/
- Гэрлэлтийн бүртгэл – 40
- Гэрлэлт цуцалсны бүртгэл – 13
- Үрчлэлт - 5
- Эцэг тогтоолт – 6
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 7
- Нас баралт – 58
- Нийт олгосон иргэний үнэмлэх – 489
- Шинээр олгосон иргэний үнэмлэх – 142
- Дахин олгосон иргэний үнэмлэх – 63
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусч солиулсан – 284
- Гадаад паспорт олголт – 35
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн – 34
- Хот доторх шилжилт хөдөлгөөн – 68 тус тус бүртгэгдсэн байна.

Төрийн архивын барилгын зураг төсөв хийлгэх, барилгын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлэхэд бодлогын дэмжлэг хүсэх тухай аймгийн Засаг даргын албан бичгийг боловсруулан Япон улсын засгийн газрын өвсний үндэс-хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн газар, Жайка олон улсын байгууллагын Монгол улс дахь суурин төлөөлөгчийн газар, Койка олон улсын байгууллагын Монгол улс дахь суурин төлөөлөгчийн газруудад болон Монгол улсын Их хурлын гишүүн Ж.Эрдэнэбат, Ч.Ундрэм, Д.Өнөрболор нарт хүргүүлж ажилласан.

Архивын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын төлөвлөгөөг 5 өдрөөр гаргаж гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. 06 дугаар сарын цахимжуулалтын мэдээг нэгтгэн баталгаажуулж Архивын ерөнхий газарт хүргүүлж ажиллалаа.

#### **Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

**Боловсрол, соёл урлаг, спортын талаар:** Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 05 дугаар сарын 12-ны А/171 тоот “Давтлага зохион байгуулах заавар батлах тухай” тушаалын дагуу сургууль бүр 05 дугаар сарын 17-ноос 06 дугаар сарын 17-нд танхимын давтлага зохион байгууллаа.

Багшийн хөгжлийг дэмжих Боловсрол сан хамтран "Дэлхийн шилдэг багш-Монголд" төслийн хүрээнд Үндэсний шилдэг багш, Үндэсний шилдэг оюутан шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж байна. Тус шалгаруулалтын нэгдүгээр шатанд шилдэг 50 багш, шилдэг 50 оюутан, хоёрдугаар шатанд шилдэг 10 багш, 10 оюутан шалгарах бөгөөд, шалгарсан 10 багш, 10 оюутны өргөдлийг дэлхийн шалгаруулалтын комиссод илгээнэ. Мөн teacherprize.mn сайтаас дэлгэрэнгүй мэдээлэл авч өргөдлөө илгээхийг багш, удирдлагуудад цахимаар мэдэгдэж ажилласан.

Японы ЖАЙКА олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй “Хөдөөгийн суурь боловсролын сургалтын чанарыг сайжруулах, оновчтой ашиглах нь” төслийн загвар аймгаар сонгогдсон Ховд аймгийн төслийн багаас боловсруулсан сургалтын 6 цахим хэрэглэгдэхүүний эхний хувилбартай танилцаж, хэлэлцэж, цаашид сайжруулан эцэслэн боловсруулах талаар зөвлөмж өгөх, төслийн үйл үр дүнг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2021 оны 6 дугаар сарын 14-ний өдрөөс 18-ныг хүртэл 5 өдөр баруун бүсийн зохион байгуулахад мэргэжилтэн Д.Нарантуяа, СБ-1 сургуулийн мэдээллийн технологийн багш Д.Мандах нар оролцлоо.

“ЕБС-ийн суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль”, 2021-2022 оны хичээлийн жилд үдийн цайг үдийн хоол болгон хэрэгжүүлж эхлэхтэй холбогдуулан Боловсрол шинжлэх ухааны яамнаас цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэл явуулж буй тогооч, нярав, эмч, удирдах ажилтныг чадваржуулах сургалтыг 2021 оны 06 дугаар сарын 06-10-ныг хүртэл 4 өдөр зохион байгуулж, сургуулийн 160 ажилтан, цэцэрлэгийн 156, нийт 350 гаруй ажилтныг хамрууллаа. Сургалтад огт хамрагдаагүй сургууль, цэцэрлэг байхгүй бөгөөд 4 өдрийн сургалтад давхардсан тоогоор 1375 ажилтныг хамрууллаа.

Орчин цагийн боловсрол, шинжлэх ухааны салбар үүсэж, хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан салбарын хэмжээнд шагналын судалгааг шинэчлэн, баяжуулахаар төлөвлөн ажиллаж байгаатай холбогдуулан нэгж байгууллагуудын ажилтан албан хаагчдын шагнал авсан тухай мэдээллийг Боловсрол шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021.06.07-ны өдрийн 2/2752 дугаар албан бичгийн хавсралтын дагуу гарган яамны шагнал хариуцсан мэргэжилтэнд хугацаанд нь цахимаар хүргүүлэв.

**Эрүүл мэндийн талаар:** Сэлэнгэ аймгийн хэмжээнд эхний давлагаанд 217, 2 дахь давлагаанд 6 сарын 22-ны өдрийн байдлаар 744 тохиолдол тус тус бүртгэгдэж нийт 961 тохиолдол батлагдсан тохиолдлоор бүртгэгдээд байна.

Нөхцөл байдлын улмаас аймгийн хэмжээнд нийт 12 цэгт ковидын тасгийг нээн ор дэлгэн ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд нийт батлагдсан 961 иргэний тархвар зүйн зураглал үйлдэн эх уурхайг тогтоох зорилгоор шуурхай хариу арга хэмжээний баг ажиллаж байна. Аймгийн хэмжээнд батлагдсан тохиолдлуудын ойрын хавьтлын иргэдтэй утсаар холбогдож, гэрээсээ гарахгүй байж халдвар хамгааллын дэглэмээ баримтлах талаарх зөвлөмж өгч, биед нь эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн эсэх талаар тодруулга аван өвчлөлийг таслан зогсоох, бууруулах зорилгоор ажиллаж байна

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04-р сарын 02-ны өдрийн Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулах тухай тушаалын дагуу Улаанбаатар хотын Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын албанаас Вероцелл вакциныг татан авчирч аймгийн хэмжээнд дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулан Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины I тунд 58100, II тунд 53500 хүнийг тус тус хамруулсан.

2021 онд магадлан итгэмжлэгдэх Дулаанхаан тосгоны ЭМТ, Шаамар сумын ЭМТ, Энэрэлт үйлс хувийн эмнэлгийг Магадлан итгэмжлэлийн шинжээчдийн багийн үнэлгээнд цахимаар оруулж үнэлүүлсэн. Тус үнэлгээнд ЭМСайдын 179 тоот тушаалын материал бүрдүүлэлтийн дагуу амжилттай явагдлаа.

**Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд:** Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй чанартай хүргэх, халамжийн шинэ үйлчилгээг

нэвтрүүлэхэд төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор 17 сум 6 тосгонд мэргэшиж, дадлагажсан 35 мэргэжилтнүүдээр төрийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

**Улсын төсвийн орлогоос:**

Халамжийн санд улсын төсвөөс тайлант хугацаанд 33840 иргэнд 9693372.3 мянган төгрөгийг олгоод байна. Үүнд:

1. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2350 иргэнд 3977510.0 мянган төгрөг
2. Нийгмийн халамжийн тэтгэмжид 1758 иргэнд 873704.1 мянган төгрөг
3. Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 1721 иргэнд 626485.6 мянган төгрөг
4. Жирэмсэн эхийн тэтгэмжид 1086 эхэд 178199.1 мянган төгрөг
5. 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 5079 эхэд 1440087.0 мянган төгрөг
6. Ихэр хүүхдийн тэтгэмжид 10 иргэнд 20000.0 мянган төгрөг
7. Эхийн алдар одонгийн тэтгэмжид 8851 иргэнд 1140600.0 мянган төгрөг
8. Насны хишиг тэтгэмжид 5121 иргэнд 800150.0 мянган төгрөг
9. Өрх толгойлсны тэтгэмж 256 иргэнд 193886.0 мянган төгрөг
10. Ахмадын настанд олгох хөнгөлөлт, тусламжид 1917 ахмадын 69902.0 мянган төгрөг
11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжид 264 иргэний 52232.3 мянган төгрөг
12. Хүнсний эрхийн бичгийн 5427 иргэнд 320615.9 мянган төгрөгийг тус тус зарцууллаа.

**Орон нутгийн төсвийн орлогоос:**

Халамжийн санд орон нутгийн төсвөөс тайлант хугацаанд 34 иргэнд 32400.0 мянган төгрөгийг олгоод байна. Үүнд:

1. Орон гэрийн хөнгөлөлт, тусламжид 13 иргэнд 15600.0 мянган төгрөг
2. ОНОТХҮ төсөлд 21 иргэнд 16800.0 мянган төгрөгийг зарцууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 452000.0 мянган төгрөгийн санхүүжилт, Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр 15315.0 санхүүжилт орж ирсэн. Мөн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 194 иргэний 241362.9 мянган төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр 1 байгууллагын 5400.0 мянган төгрөг орж ирсэн байна.

№	Хөтөлбөрийн нэр	2021 оны эхний үлдэгдэл	Энэ онд шинээр нэмэгдсэн	Эргэн төлөлт хийсэн дүн	Эцсийн үлдэгдэл
1	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	356,238,385	119,000,000	60,505,025	414,733,360
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	63,972,960	24,000,000	19,363,670	68,609,290
3	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	399,248,610	46,000,000	133,018,730	312,229,880

4	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	27,788,500	15,000,000	8,150,000	34,638,500
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	152,463,075		20,325,475	132,137,600
6	<b>Нийт дүн</b>	<b>999,711,530</b>	<b>204,000,000</b>	<b>241,362,900</b>	<b>962,348,630</b>

**Зарлагын талаар:**

1. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 192 хүнд 295.0 мянган төгрөг,
2. Ажилд зуучлах үйлчилгээнд 246 хүнд 662.1 мянган төгрөг,
3. Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт 37 хүнд 165000.0 мянган төгрөг,
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 14 хүнд 58080.0 мянган төгрөг,
5. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 5 хүнд 15000.0 мянган төгрөг,
6. Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ, хөдөлмөрийн яармаг, өдөрлөг зохион байгуулах, хууль тогтоомж, эрх зүйн актын уулзалт, хэлэлцүүлэгт 120.0 мянган төгрөг,
7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхэд 60.0 мянган төгрөг

Нийт 239217.1 мянган төгрөг зарцуулан ажилласан байна.

**Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:** “ХҮҮХДИЙН ТУСЛАМЖИЙН 108 УТАСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”-өөс хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой 11 дуудлага мэдээлэл бүртгэгдсэн. Үүнд:

Хүүхэд хамгааллын дуудлага-2

Хүүхдийн эрхийн зөрчлийн дуудлага-4

Зөвлөгөө хүссэн дуудлага-3

Мэдээлэл хүссэн дуудлага-2 байна.

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрийг “ОДОО АРГА ХЭМЖЭЭ АВЪЯ” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхээр “Хөдөлмөр эрхлэгч хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны удирдамж”-ийн дагуу 2021 оны 6 дугаар сарын 10-наас 9 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл зохион байгуулж байна. Уг өдрөөр уриалга, постер, шторкыг “Сэлэнгэ хүүхэд”, “Сэлэнгэ залуучуудын хөгжлийн төв”, “Сэлэнгэ сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ” болон 17 сум 6 тосгоны орон нутгийн цахим хуудсаар олон нийтэд түгээсэн.

Ардын хувьсгалын 100 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 90 жил, Залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан залуучуудын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, оюутан залуучуудын эрдэм судлал бүтээлийн ажлыг дэмжих зорилгоор Эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурлыг зохион байгууллаа. Нийт 21 илтгэл ирүүлснээс 2 дугаар шатны шалгаруулалтад 13 илтгэл тэнцэж, 11 илтгэгч илтгэлээ цахимаар хэлэлцүүлж, эхний 5 байр шалгарууллаа.



### **Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:**

**Мал эмнэлгийн үйлчилгээний талаар:** Мэдээ мэдээллийн сан бүрдүүлэх тухай тушаалын хавсралт мэдээг сумдын мал эмнэлгийн тасгаас авч нэгтгэсэн ба халдварт өвчин бүртгэгдээгүй, 04 хавсралт мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний дагуу 323150 толгой мал, амьтан буюу 34 хувийг хамруулсан байна, 06 хавсралт халдваргүйтгэлийн арга хэмжээний дагуу **нийт-489260м2 талбайд** халдваргүйтгэл хийж, нийт-2850ш сэг зэм булж, шатааж устган халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/101 тоот "Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай" захирамж, А/64 тоот "Мал, амьтны халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, сэг зэм устгах, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах тухай" захирамжуудаар халваргүйтгэлийн арга хэмжээний дагуу 345ш малын хашаа хорооны-29800м2, 34ш гахайн байрны-3240м2, 45 шувууны байрны-3450м2, 671ш тээврийн хэрэгслийн-4570м2, 176ш зоорины-8750м2, 37ш тэжээлийн агуулахын-2400м2, 85ш худаг уст цэгийн-3240м2, 45тонн хэвтэр бууцны-94590м2, бэлчээр-56400м2, голомтын бүсийн-2450м2 устгалын цэгийн талбайн-4570м2, нийтийн эзэмшлийн талбайн-275800м2 талбай, **нийт-489260м2 талбайд** халдваргүйтгэл хийж, нийт-2850ш сэг зэмийн булж, шатааж устган халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, ЗГ-ын 225-р тогтоолын 1,2,3-р хавсралтаар төлөвлөгөөт вакцинжуулалтыг технологит хугацаанд давхардсан тоогоор 11 нэр төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд энэ онд нийт 1241.4 мян/ толгой мал амьтан хамруулахаас 323150 толгой мал, амьтан буюу 34 хувийг хамруулан ажиллаж байна. Мал сүргийн эрүүл мэндийн үзлэгийг 323150 толгой малд хийж ажилласан.

Мал эмнэлгийн цахим системд аймгийн хэмжээнд хагас жилийн байдлаар: **Хүнсэнд:** 5656 гэрчилгээгээр адуу 1582, үхэр 2857, хонь 17453, ямаа 8732, тэмээ 14, гахай 91, тахиа 46 толгой буюу нийт **30775** толгой мал, амьтан, 384567кг мах, махан бүтээгдэхүүн, 979176кг сүү, сүүн бүтээгдэхүүн, 44396ш арьс шир, түүхий эд буюу нийт 1408139кг, ширхэг бүтээгдэхүүн:

**Шилжилт хөдөлгөөн:** 1608 гэрчилгээгээр адуу 4773, үхэр 4457, хонь 11704, ямаа 7903, тэмээ 7, гахай 190, тахиа 150, нохой 2 толгой буюу нийт 29186 толгой мал, амьтан шилжилт хөдөлгөөн хийсэн байна. Үүнээс: Өөр аймаг, сумдаас ирсэн 19102 толгой /отор 16954, үржилд 1997, уралдаан 151/, өөр аймаг сумд руу явсан 6617 толгой /отор 2287, үржилд 4182, уралдаан 148/, аймаг дотроо 3467 толгой /отор 1475, үржилд 1932, уралдаан 60/ мал, амьтан тус тус хийгджээ.

Нийт 7264 гэрчилгээгээр адуу 6355, үхэр 7314, хонь 29157, ямаа 16635, тэмээ 21, гахай 281, тахиа 196, нохой 2 толгой буюу нийт 59961 толгой мал, амьтан, 384567кг мах, махан бүтээгдэхүүн, 979176кг сүү, сүүн бүтээгдэхүүн, 44396ш арьс шир, түүхий эд буюу нийт 1408139кг, ширхэг бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ олгож, цахим мэдээллийн сан үүссэн байна.

**Хөдөө аж ахуйн талаар:** Улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, онцгой дэглэм мөрдөн ажиллаж байгаа энэ цаг үед бид 2021 оны хаврын тариалалтын бэлтгэлийг хангахад чиглэсэн олон ажил арга хэмжээг төлөвлөн онцгой дэглэм мөрдөн ажиллаж байгаа энэ цаг үед бид улаанбуудай, төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч засгийн газраас хөнгөлөлттэй зээл, төмс, хүнсний ногооны үр, техник тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис, шатахууныг

хөнгөлөлттэй нөхцөлөөр олгохоор ажиллаж байгаа тул сумдын засаг дарга нарт нийт тариалах талбайн 80-иас доошгүй хувьд улаанбуудай тариалах гэрээ хийх, орон нутагтаа “Өрхийн тариалан” хөдөлгөөн өрнүүлэх замаар 2021 оны тариалалтын төлөвлөгөөг давуулан тариалах чиглэл хүргүүлэн ажилласан.

Аймгийн хэмжээнд Хаврын тариалалтын урьдчилсан дүнгээр нийт 193 мян,га талбайд үр тариа, тэжээлийн ургамал, тосны ургамал, төмс, хүнсний ногоо тариалахаас улаанбуудай 135мян,га талбайд, арвай 3676га талбайд, Овьёос 4235га талбайд, тэжээлийн ургамал 6894га талбайд, тосны ургамал 31мян,га талбайд, төмс 2474га талбайд, хүнсний ногоо 2411га талбайд тариалсан байна.

Хаврын тариалалтын чанарын соёололтын нийт 135мян,га талбайд соёололтын үзлэг хийхэд үүнээс 25487 га талбай буюу 18.8 % нь онц, 96.7 мян,га талбай буюу 71.3% нь сайн, 13097 га талбай буюу 9.6% нь дунд дүнтэй байна. Хаврын тариалалтын чанарын соёололтын мэдээг Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэн ажилласан.

Мөн хүнсний ногооны үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээг хангах зорилтын хүрээнд “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас “Өрхийн тариалан хөдөлгөөн өрнүүлэн” ногоочдыг үрээр хангах зорилгоор хүнсний ногооны үрийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн 17 сумын 1050 иргэнээс 11 нэр төрлийн 94,3тн хүнсний ногооны үрийн захиалга авч Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлснээр аймгийн хэмжээнд нийт 16тн төл сонгино, 6,2тн сармис, 100кг лууван, 20кг манжингийн үрийг хөнгөлөлттэй үнээр сумдад олгоод байна.

**“Ажлын байр дэмжих”** зээлийн хүрээнд нийт өссөн дүнгээр арилжааны банкнуудад 1290 аж ахуйн нэгж, иргэдээс 121.5тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт ирснээс 727 аж ахуйн нэгж иргэдэд 39.6 тэрбум төгрөгийн 3 хувийн хүүтэй зээл олгогджээ. Мөн 68 аж ахуйн нэгж, иргэд 2,8 тэрбум төгрөгийн өндөр хүүтэй зээлээ хүү багатай зээл рүү шилжүүлсэн байна.

**“Хөдөө аж ахуйг дэмжих”** зээлийн хүрээнд арилжааны банкнуудад газар тариаланд 79 аж ахуйн нэгж, иргэдээс 6,7тэрбум төгрөгийн ирүүлснээс 55 аж ахуйн нэгж иргэнд 3,0 тэрбум төгрөг, малчдыг дэмжихэд 1182 аж ахуйн нэгж, иргэдээс 14,5 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт ирснээс 782 малчинд 8,7 тэрбум төгрөг нийтдээ 837 аж ахуйн нэгж иргэдэд 11,7 тэрбум төгрөгийн 3 хувийн хүүтэй зээл олгогджээ.

2021 оны 6 сарын байдлаар 759552 толгой хээлтэгч мал төллөхөөс 682801 толгой мал төллөөд байна. Үүнээс ингэ 73, гүү-23251, Үхэр-80775, эм хонь 314506, эм ямаа-263647 төллөж мал төллөлт 88.9 хувьтай, төл бойжилт 99,5 хувьтай байна. Төлийн хорогдол 2469, том малын зүй бус хорогдол 5490 мал байна.

ХХААХҮЯ-наас ирүүлсэн удирдамжийн дагуу аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/129 тоот захирамжаар Орхон, Сайхан, Алтанбулаг, Түшиг, Цагааннуур, Мандал, Баянгол, Хушаат, Ерөө, Баруунбүрэн сумдад 6744 бог, 6100 бод нийт 12853 мян.толгой малд үзлэг ангилалт хийх цөм сүрэг бүрдүүлэн баталгаажуулах ажлыг эхлүүлж хагас жилийн байдлаар Орхон үүлдрийн 2934, Хангай үүлдрийн 2637, Ерөө үүлдрийн хэсгийн 1173 нийт 6744 толгой бог малд үзлэг ангилал хийж үржлийн жишигт тэнцсэн 4000 толгой бог малыг ээмэгжүүлж бүртгэлжүүлэн цөм сүрэг бүрдүүлэх ажлыг зохион байгууллаа. Мал сүрэгт хийх хаврын технологит ажил үргэлжилж байна.

Малын удмын сангийн үндэсний төвийн гэрээт техникчдээр дамжуулан Мандал суманд гол штейн үүлдрийн гүн хөлдөөсөн үрээр 85 үнээнд, Хушаат суманд Казакын

цагаан толгойт, герефорд үүлдрийн үрээр 28, Зүүнбүрэн суманд герефорд үүлдрийн үрээр 45 нийт 158 үнээнд зохиомол хээлтүүлгийн ажил хийгдлээ.

**Байгаль орчны талаар:** Хил дамнасан түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор Алтанбулаг, Түшиг сумдын нутагт байгуулсан шороон зурвас арчлах ажлын санхүүжилт 5 сая төгрөгийг олгосон. Ажлын гүйцэтгэл нь Алтанбулаг сумаас эхлэн хийж гүйцэтгээд байна.

Сүхбаатар сумын 1-р баг Хонгор морьтны хогийн цэгийн талбайд “Аюултай хог хаягдлын түр хадгалах байгууламж”-ийн барилгын ажлын суурийг цутгаж ажиллаад байна.

Аймгийн аялал жуулчлалын маршрут, амралтын газруудын байршлыг харуулсан гар утасны аппликейшныг “Аялал жуулчлалын хөгжлийн төв”-өөр гүйцэтгүүлэх гэрээг байгуулаад байна.

“2021-2025 онуудад хэрэгжүүлэх ойн менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны Ойн нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, арчилгааны огтлолт, ойн замын асуудал, ойжуулалтын ажлыг нэмэгдүүлэн төлөвлөх, ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг нэмж төлөвлөх зэрэг саналуудыг тусган, батлуулахаар шийдвэрлэсэн.

Ардын хувьсгалын 100 жил, аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг угтан нийтийн эзэмшлийн талбай болон наадмын талбайн орчимд талбайд нийт 416 модыг шилжүүлэн суулгасан “Тод газар” ХХК-ний ажлын гүйцэтгэлийг актаар хүлээн авсан.

Сүхбаатар сумын нийтийн эзэмшлийн талбайнуудад тарьсан модыг Сүхбаатар суманд хүлээлгэн өгч, усалгаа арчилгааг хариуцуулахаар тогтлоо.

“Агрофорест” ХХК-ний Жавхлант суманд хийсэн ойн зурвасын ажлын гүйцэтгэлийг сум нь хүлээн авч хамтран ажиллах гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн.

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар:** Газар өмчилж, эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн байгууллагаар хэмжилт, боловсруулалт хийлгэсэн 21нэгж талбарын кадастрын зургийг хүлээн авч аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн сангийн Лэнд менежер програмд бүртгэж баталгаажуулсан.

Атаршиж орхигдсон тариалан болон атаршсан газруудын тоон зургийн атрибут мэдээллийг ГЗБГЗЗГ–аас ирсэн загварын дагуу бэлтгэн хүргүүлээ.

Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт геодезийн цэг тэмдэгтийн тооллого явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилго бүхий аймгийн Засаг даргын 2021.06.24-ны 01/648 тоот албан бичгийн хүрээнд 17 сумын нутаг дэвсгэрт цэг тэмдэгтийн тооллогыг хийх чиглэлийг хүргүүлж ажилласан. GNSS-ийн дэд сүлжээний /12-24 цагийн GNSS-ийн хэмжилт хийсэн/ цэгийг тулгуур болгон хяналтын хэмжилт хийж, байр зүйн зурагтай давхцуулан тайланг хүргүүлсэн.

**Орон нутгийн өмчийн талаар:** Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор Дуудлагын худалдаагаар худалдаалах үндсэн хөрөнгийг холбогдох хууль журмын дагуу 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулахаар зар мэдээг зарлуулан ажиллаж байна.

2021 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д 1 агентлаг, 17 сум, 18 сургууль цэцэрлэгийн төлөвлөгөөг хянан баталгаажуулж Сангийн яаманд илгээж батлуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021оны ХАА-ны төлөвлөгөөнд 61 төсөл арга хэмжээ батлагдсанаас Захиалагчаас 42 төсөл арга хэмжээний ажлын даалгавар, зураг

төсөв, техникийн тодорхойлолт ирүүлсэн дарууд ил тод, нээлттэй 100 хувь цахим хэлбэрээр хуулийн хугацаанд зохион байгуулан ажиллаж байна. Үүнээс тендер шалгаруулалт нь хүлээн авах шатандаа байгаа - 19, үнэлгээ хийж байгаа - 8, гэрээ байгуулах эрх олгосон - 21, Зураг төсөв ирээгүй -19 төсөл арга хэмжээ байна.

### **Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:**

#### **Алтанбулаг сум:**

Сумын Засаг даргын 2021 оны “Эргүүл жижүүр томилох тухай” А/122, А/130 тоот захирамжийн дагуу автозамын шалган нэвтрүүлэх цэг, шуурхай штабын жижүүрт төр төсвийн байгууллагын 97 албан хаагч үүрэг гүйцэтгэж байна. Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын дархлаажуулалтад сумын Засаг даргын 2021 оны “Дархлаажуулалтын ажлын хэсэг байгуулах тухай” А/95 тоот захирамжийн дагуу Синофарм вакцины 1,2 дугаар тунг 04 дүгээр сарын 05-наас 06 дугаар сарын 02-ны өдрүүдэд 1275 иргэнийг хамруулж, уг ажилд давхардсан тоогоор 104 албан хаагч ажилласан.

Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолоор суманд “Төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх Хур систем” төслийн хүрээнд иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр төрийн 11 байгууллагын 55 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг 85 иргэнд гарган өгч ажилласан.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийг эрчимжүүлэх тухай” А/15 тоот захирамжийн дагуу төр, төсвийн 7 байгууллага, худалдаа үйлчилгээний 50 газрын нийт 265,762 м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн хэсгийн хорооны бүрэлдэхүүнд төр, төсвийн байгууллагын 57 албан хаагч ажилласан.

Сумын Онцгой комисс 4 удаа хуралдаж цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний талаар хэлэлцэж, шийдвэрт үндэслэн сумын Засаг даргын 2021 оны “Коронавируст халдвар ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх болон гамшгаас хамгаалах ажлыг эрчимжүүлэх тухай” А/129, “Хөдөлгөөн хязгаарлах тухай” А/130, “Хөдөлгөөн хязгаарласан хугацааг сунгах тухай” А/131 тоот захирамжуудыг тус тус гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улаанбаатар хотоос бүтээн байгуулалтын ажлаар ирж гэрийн ажиглалтад байсан 1 иргэнээс Коронавируст халдвар батлагдсан. Одоогийн байдлаар сумын хэмжээнд 4 голомтын 26 иргэн халдвар авч эмчлэгдэж байна. Тус иргэдийн ойрын болон дам хавьтлыг тодорхойлох тандалт судалгааны ажлыг сумын Засаг даргын 2021 оны “Сумын шуурхай штабыг шинэчлэн байгуулах тухай” А/46 тоот захирамжийн дагуу “Хариу арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажиллагаа- зохицуулах” багийн 6 гишүүн хариуцан ажиллаж байна.

Сумын Эрүүл мэндийн төвийн дэргэд коронавирусын халдвараар өвдөж батлагдсан тохиолдлыг эмчлэх 18 ортой тасгийг шинээр тохижуулж бэлэн байдлыг хангаж эмчлүүлэгчдийг хүлээн авч ажиллаж байна. Тус тасагт Эрүүл мэндийн төвийн 4 ажилтан, албан хаагч ажиллаж байна. Коронавируст халдвар /ковид-19/-тай голомтын бүс нутгаас ирсэн 94 иргэдэд тандалт судалгааг хийж PCR оношлуурын шинжилгээнд 154, түргэвчилсэн оношлуурын шинжилгээнд 168 иргэдийг хамруулж өдөр бүр сорьцыг зөөвөрлөж Эрүүл мэндийн газарт мэдээ өгч ажиллаж байна.

Боловсрол шинжлэх ухааны яамны сайдын 2021 оны “Хичээл сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” А/165 тоот тушаалын дагуу сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөр дуусгавар

болгож сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суралцагч хүүхдүүдийн амралт эхэлсэн. Багш ажилчид хүүхэд хамгааллын ажилд онцгой анхаарч өдөр бүр бүлгийн цахим хаягаар мэдээ мэдээлэл, зураг, сэрэмжлүүлэг байршуулан эцэг эхчүүдэд хүүхэд хамгааллын тухай хуулийг тайлбарлан танин мэдүүлэх, харилцан ярилцах, гарч болзошгүй эрсдэлээс сэргийлэн ажиллаж байна.

**Баруунбүрэн сум:**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IV хуралдааныг 2021 оны 06 сарын 17-ны өдөр цахимаар хуралдуулж сумын малчин, мал бүхий иргэдийн малын тоо толгойд ногдуулах албан татварын хэмжээг малын төрөл бүрээр тогтоож “Татварын хууль”-д заасан хугацаанд орон нутгийн төсөвт төвлөрүүлэн, зориулалтын дагуу зарцуулахыг сумын Засаг дарга /Ц.Сэлэнгэ /-д үүрэг болголоо.

*Малын тоо толгойд ногдуулах албан татварын хэмжээ /малын төрлөөр/*

дд	Малын төрөл	Толгойн тоо	Татварын хэмжээ
1	Тэмээ	1	2000
2	Адуу	1	2000
3	Үхэр	1	500
4	Хонь	1	500
5	Ямаа	1	2000

Сумын Засаг даргын 2021 оны “Хязгаарлалтын дэглэм тогтоож, цагийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/93 тоот захирамж, “Хязгаарлалтын хугацааг сунгаж, зарим үйл ажиллагааг хориглох тухай” А/98 тоот захирамжаар суманд хөдөлгөөний хязгаарлалт тогтоож орох, гарах хөдөлгөөнийг хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд хаагаад байна. Мөн сумын Онцгой комиссын 2021 оны “Түр тусгаарлан ажиглах байрыг бэлтгэх тухай” 07 тоот тогтоол, сумын Засаг даргын “Тандалт, хариу арга хэмжээний баг байгуулах тухай” А/96 тоот захирамж гарч тандалт судалгааны баг шинэчлэгдэн үйл ажиллагаагаа эрчимжүүлэн ажиллаж байна.

Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг 05 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн зохион байгуулахад 12-р ангийн нийт 24 суралцагчдад 7 төрлийн хичээлээр 89 цагийн давтлагыг халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгууллаа.

Сумын хэмжээнд Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 6 дугаар сард 1-р тунд 14, 2-р тунд 1658 хүнийг хамруулж ажиллалаа.

Ногоочдын үйл ажиллагааг эрчимжүүлэн дэмжих зорилгоор ХХААХҮЯ-аас хөнгөлттэй үнээр олгосон 600 кг төл сонгино, 300 кг сармис, 1 кг хүрэн манжин, 0,5 кг шар манжин, 5,5 кг лууван, 400 гр чинжүү, 90 ширхэг хүлэмжийн хэмх, 2 тн “Сэлэнгэ” сортын төмсгийг давхардсан тоогоор 80 гаруй ногоочинд тараан өгсөн байна. Мөн өвс, ногоон тэжээлийн фонд үүсгэх зорилгоор аймгийн ХХААГ-аас олгосон 3 тн овъёосны үрийг нийгмийн хариуцлагын хүрээнд “Бүрэн бумбат” ХХК-тай тохиролцон 1 тн улаанбуудайг нэмж ногоон тэжээл тариалаад байна.

Сумын хэмжээнд 22 аж ахуй нэгж, 11 иргэн 9862 га талбайд улаанбуудай, 50 га талбайд овъёос, 952 га талбайд тосны ургамал, 890 га талбайд ногоон тэжээл, 90 гаруй ногоочин 100 га талбайд төмс, 85 га талбайд хүнсний ногоо тариалаад байна.

Сумын Засаг даргын 2021 оны “Соёлолтын үзлэг явуулах тухай” А/94 тоот захирамжийн дагуу сумын соёлолтын үзлэгийн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа.

2021 оны эхний хагас жилийн байдлаар Мал эмнэлгийн цахим бүртгэлийн нэгдсэн системд хүнсэнд адуу 420, үхэр 688, хонь 2360, ямаа 1508, гахай 6, тэмээ 5 нийт 4987 толгой, мах 57731 кг, сүү 1936 л тус тус бичигдсэн байна.

#### **Баянгол сум:**

Коронавирусын халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлж тархалтыг бууруулах зорилгоор сумын Засаг даргын 2021 оны А/108 тоот “Түр хязгаарлалт тогтоож, зарим байгууллагын үйл ажиллагааг хориглох тухай” захирамжийн дагуу сумаас гарах, орох болон сум доторх зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 07 дугаар сарын 01-ний өдрийн 18:00 цаг хүртэл хориглож, хүнсний чиглэлээр худалдаа эрхлэгчдийн ажиллах цагийн хуваарийг 09:00-15:00 цагийн хооронд байхаар тогтоож, 18 градусаас дээш архи согтууруулах ундааг хязгаарлалтын хугацаанд зарж борлуулахыг хориглоод байна. Мөн сумын орон гарах чиглэлд 24 цагийн 2 постод 6 албан хаагчийн байнгын үүрэг гүйцэтгэж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж хяналт шалгалтыг явуулж байна.

Сумын хэмжээнд Цагдаагийн хэсэг, Гал түймэр унтраах 40-р анги, Ерөнхий боловсролын сургууль, Баянгол цэцэрлэг, Засаг даргын Тамгын газар хамтран 24 цагийн пост 2 цэгт 4 албан хаагч үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2020 оны “Шуурхай штаб байгуулж ажлын тусгай горимд шилжүүлэх тухай” А\254 дүгээр захирамжийн дагуу Засаг даргын Тамгын газрын байранд шуурхай штабыг байрлуулан 24 цагийн хариуцлагатай жижүүрийг томилж, үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээ, мэдээллийг аймгийн Онцгой комисс болон холбогдох байгууллагад 94244802 дугаарын утсаар болон цахимаар буюу [Bayangolshuurhaishtab@gmail.com](mailto:Bayangolshuurhaishtab@gmail.com) хаягаар хүргүүлэн ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн засаг даргын 2021 оны “Ариутгал халдваргүйтгэлийг эрчимжүүлэх тухай” А/15 захирамжийн дагуу 05 дугаар сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 25-ны хооронд сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төр төсөв, хувийн хэвшлийн 11 аж ахуйн нэгж байгууллагын 35,000 м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг харьяалагдах нутаг дэвсгэрийн хэмжээнд сумын сонгуулийн хороонд 5, 16-4-1, 16-4-2, 16-4-3 дугаар хэсгийн хороодын санал авах байруудад 27, нийт 32 төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч, хамгаалалт, хэв журам сахиулах чиглэлээр 6 цагдаа, Монгол Улсын Засгийн газрын 152 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс ариутгал халдваргүйтгэл хийх эмнэлгийн байгууллагын ажилтан буюу 3 эмч, Онцгой байдлын албан хаагч 3, үйлчилгээний ажилтан 3, тохижилт үйлчилгээний 2 нийт 17 төрийн албан хаагч тусгай үүргийн чиглэлээр нэмэлтээр ажиллаж, сонгуулийг хуулийн хүрээнд зохион байгуулан ажиллалаа.

Сумын сонгуулийн хороо, санал авах байрны гишүүдээс гадна Сонгогчийн санал авах үйл ажиллагаа 07:00 цагт хэвийн эхлүүлж, санал хураалтын ирцийн мэдээг цаг тутам хэсгийн хороодоос авч аймгийн Сонгуулийн хороод мэдээлж, Voter аппликешнээр 11:00, 15:00, 19:00, 22:00 цагуудад QR код уншуулан мэдээг хугацаанд нь дамжуулж ажиллалаа.

Санал авах, тоолох үйл ажиллагаа хуулийн хугацаанд буюу 22:00 цагт өндөрлөж, сонгуулийн үр дүнгээр сумын хэмжээнд нэр дэвшигч У.Хүрэлсүхийн төлөө 1376 сонгогч

саналаа өгч 71,9 хувь, С.Эрдэнийн төлөө 105 сонгогч саналаа өгч 5,5 хувь, Д.Энхбатын төлөө 268 сонгогч саналаа өгч 14,0 хувь, огт санал тэмдэглээгүй 265 сонгогч 8,6 хувийн дүнгээр нэр дэвшигч У.Хүрэлсүх олонхын саналыг авсан.

Үргэлжлэн орсон борооны улмаас “Хараа” голын усны төвшин эрс нэмэгдэж сумын Засаг даргын 2021 оны “Үер усны аюулаас урьдчилан сэргийлж айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх тухай” А/102 тоот захирамжийн дагуу айл өрхүүдэд сонор сэрэмж, болгоомжтой байхыг зөвлөж ГТУА-40-р ангийн зааврын дагуу эрсдэлт нөхцөлд байгаа 17 өрхөд нүүх мэдэгдэл өгч ажилласан. Мөн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, ГТУА-40-р анги, “Төгс зам” ХХК-ий хамтарсан ажлын хэсэг 06 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд үер усны аюулыг зогсоох зорилгоор 4 техник 10 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж хайрга, шороог зөөвөрлөн үерийн далан босгох ажлыг хийж гүйцэтгэсэн.

Сумын Засаг даргын 2021 оны “Малын хагас жилийн түүвэр судалгаа зохион байгуулах тухай” А/101 тоот захирамжийн хүрээнд 3 багийн хэмжээнд 42 өрхийн нийт 55132 толгой малыг тоолж, програмд шивж оруулсан.

Аймгийн ХХААГ-ын 2021 оны “Чиглэл ирүүлэх тухай” 376 тоот албан бичиг, аймгийн Засаг даргын 2021 оны “Аян зохион байгуулах тухай” А/130, “Мал сүрэгт үзлэг ангилалт хийх тухай” А/135, сумын Засаг даргын 2021 оны “Мал бүртгэлжүүлэлтийн аян зохион байгуулж, мал сүрэгт үзлэг ангилалт хийх тухай” А/87 тоот захирамжуудын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/72 тоот тушаалаар батлагдсан “Малд үзлэг ангилалт хийх заавар”-ыг баримтлан 17 суурийн 4013 хонь, 1344 ямаанд ангийн ангилалт хийв.

#### **Ерөө сум:**

Сумын Онцгой комисс цаг үеийн байдал болон аймаг, улсын Онцгой комиссын гаргаж буй шийдвэрийг үндэслэн 4 удаа хуралдаж, холбогдох шийдвэрүүдийг гарган ажиллаж байна. Сумын Онцгой комиссоос 3417 иргэн яаралтай бичиг гаргуулсан байна.

Мэдээлэл сурталчилгааны ажлын хэсэг “Ерөө сумын Онцгой комисс” фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд Коронавирус халдвар /Ковид-19/-ын талаар улс, аймаг, сумын Онцгой комиссын цаг үеийн мэдээ 27, сумын Засаг даргын 2 удаагийн дүрс бичлэг, вакцинжуулалтын талаар 5, цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээ 6, Эрүүл мэндийн төвийн гаргасан “Ковид-19”-ын тухай заавар, зөвлөмж 11, цагаан хоолойгоор 1,2 дугаар багийн иргэдэд сэрэмжлүүлэг мэдээ 4 удаа тус тус хүргэсэн байна.

Онцгой нөхцөл байдалтай холбогдуулан өдрийн хариуцлагатай жижүүрээр 16 албан хаагч, хяналтын постод 6, төр төсвийн 4 нийтдээ 26 албан хаагч үүрэг гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд сумын хэмжээнд гэрийн тусгаарлалтад 145 өрхийн, 46 том хүн, 23 хүүхэд, өрхөд хамт 374 нийт 443 иргэн тусгаарлалтад байна.

“Болд төмөр Ерөө гол” ХХК-аас зохион байгуулсан “Би зурах дуртай”, “Миний ирээдүйн мэргэжил” цахим сургалтад 5-16 насны 4 ангилалд 113 хүүхэд хамрагдаж насны ангилал бүрд 5 байр шалгаруулж, оролцсон бүх хүүхдүүдэд гарын бэлэг өгсөн.

Ажил хайгчаар бүртгүүлсэн 23 иргэнийг Болд төмөр Ерөө гол” ХХК болон ОНОТХҮ-ний хүнсний ногоо тариалах төсөлд хамруулж 7 ажлын байр, мөн “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-т хамрагдсан 4 иргэн, нийт 23 иргэнийг ажлын байранд зуучилсан байна.

Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр сумын Эрүүл мэндийн төвд 21 ортой “Ковидын тасаг”-ийг шинээр нээж, тус тасагт Хүдэр, Бугант, Ерөөгөөс коронавирусын батлагдсан тохиолдлын 29 хүн хэвтэн эмчлүүлж байгаагаас насанд хүрэгч 21, бага насны хүүхэд 8 байна.

Сумын 99 иргэнээс ПСР шинжилгээ авахад 2 иргэнээс “Ковид-19” илэрч нийт батлагдсан тохиолдлын тоо 15 болсон байна. Түргэвчилсэн шинжилгээнд нийт 556 иргэнийг тус тус хамруулсан байна.

“Эрүүл хүүхэд-Эрүүд шүд” аяны хүрээнд Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 53 сая төгрөгийн өртөгтэй “Шүдний кабинет”-тэй болсон байна.

Бороо хур ихсэж голын усны түвшин нэмэгдэж үерийн онц аюултай байдалд хүрч голын эргээр суурьшиж байсан иргэд, малчид үерийн усанд боогдож аймгийн Онцгой байдлын газар, төр төсвийн байгууллагын ажилтан, албан хаагчидтай хамтран 14 өрхийн 35 иргэнийг үерийн уснаас гарган нүүлгэн шилжүүлсэн байна.

Үер усны аюулаас болгоомжлох, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээний хүрээнд 1,2-р багийн 42 айл өрхийн нийт 63 иргэнд ухуулга сурталчилгаа хийж ажиллалаа.

Энэ онд 18 аж ахуй нэгж, 14 иргэн нийт 12941,06 га талбайд үр тариа, 60 га талбайд төмс, 70 га талбайд хүнсний ногоо тариалаад байна. Улаан буудай 10286,06 га, арвай 614 га, рапс 1376 га, оввёос 520 га, ногоон тэжээл 145 га-д тариалсан.

Хагас жилийн “Малын түүвэр тооллого”-оор 3 багийн 107 өрхийн малыг тоолсон байна.

Шимэгчтэх өвчний хүрээнд туулгалтад хонь 32674, ямаа 34896, үхэр 1765, адуу 4376, нохой 1615, гахай 606, нийт 91824 мал амьтанд хамруулж, боловсруулалтад хонь 32674, ямаа 34898, үхэр 28329, нохой 404, гахай 151 нийт 96456 мал амьтанд хийсэн.

#### **Жавхлант сум:**

Тус суманд Коронавируст халдвар “Ковид-19”-ын сэжигтэй тохиолдол 06 дугаар сарын 09-ний өдөр илэрч сумын Онцгой комисс болон Шуурхай штаб хуралдаж холбогдох шийдвэрүүдийг гаргалаа.

Сумын Засаг даргын 2021 оны “Хөдөлгөөнд түр хязгаарлалт тогтоох тухай” А/72 захирамжаар 06 дугаар сарын 11-14-ийг хүртэл сумын орох гарах хөдөлгөөнийг хязгаарласан.

Сумын хэмжээнд Коронавируст халдвар /Ковид-19/-аар нийт 13 тохиолдол батлагдсан. Эрүүл мэндийн төвийн “Ковидын тасаг”-ийг нээж, коронавируст халдвар /Ковид-19/-тай 25 иргэн хэвтэн эмчлүүлж, дотуур байрны тусгаарлах өрөөнд 3 том хүн 1 хүүхэд тусгаарлагдаж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай” А/15 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх “Жавхлант хаалга барих” тендерийн ажил 80 хувьтай хийгдэж байна.

Ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн эрэн хайх аврах бүлэг үерт автсан 11 айл өрхийг нүүлгэн шилжүүлсэн.

Хүнс хөдөө аж ахуйн яамнаас хаврын тариалалтад дэмжлэг үзүүлэн хүнсний ногооны үрийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож 36 иргэнд 2.415.0 төгрөгийн үнэ бүхий сонгино, сармис, лууван, манжин гэх мэт хүнсний ногооны үрийг олгож, 3 иргэнд 32 м2 бүхий зуны нийлэг хальсан хүлэмж олгосон. Тус сумын хэмжээнд улаанбуудай 8328 га, оввёос 60 га, ногоон тэжээл 290 га, рапс 2580 га, төмс, хүнсний ногоо 206 га нийт 11258 га талбайд тариалалт хийгээд байна.

Сумын хэмжээнд 115 гарал үүсэл бичигдсэн бөгөөд үүнээс үхрийн мах 10640 кг, адууны мах 1080 кг хонины мах 3095 ямааны мах 727 кг тус тус махыг зах зээлд нийлүүлсэн.



Аймгийн Засаг даргын А/135 тоот “Малд үзлэг ангилалт явуулах тухай”, сумын Засаг даргын А/63 тоот “Малд үзлэг ангилалт хийх тухай” захирамжийн дагуу 6 өрхийн 2200 бог малын үзлэг ангилалтыг хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг сурталчилан сумандаа малын тоо толгойн албан татвар авах журам боловсруулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 12 тоот тогтоолоор малын тоо толгойн албан татварын хэмжээг толгой тус бүр дээр адуу 2000, үхэр 800, тэмээ 2000, ямаа 2000, хонь 800 төгрөг байхаар тус тус тогтоож, хууль зүйн яаманд бүртгүүлэхээр хүргүүлээд байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 185 тоот тогтоолоор батлагдсан “Заавал хийх дархлаажуулалт”-д 0-15 насны хүүхдүүдийг үндэсний товлотт вакцинд 100 хувь хамруулан ажиллаж байна. Мөн коронавирусын цар тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Коронавирусын вакцинд” 18 наснаас дээш насны 2216 иргэдийг бүрэн хамруулсан.

### **Зүүнбүрэн сум:**

Сумын Засаг даргын 2021 оны А/31 тоот “Онцгой комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” захирамжаар орон нутагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, байгууллагуудыг хуваарилан хариуцуулж үйл ажиллагаанд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Сумын Онцгой комиссын 2021 оны “Зорчих хөдөлгөөнийг түр хугацаагаа хязгаарлах тухай” 03 тоот тогтоолоор сумаас орох, гарах хөдөлгөөнийг 2021 оны 06 дугаар сарын 18-23-ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд хязгаарласныг аймгийн Онцгой комиссоос ирүүлсэн чиглэлийн дагуу дахин 72 цагийн хугацаагаар сунган, хяналтын постыг 24 цагаар ажиллуулж байна.

Сумын Засаг даргын 2021 оны “Гэрийн тусгаарлалтад байгаа иргэдийг хянах хяналтын баг, хүүхэд хамгааллын баг байгуулах тухай” А/33 тоот захирамжаар эрсдэлтэй бүс нутгаас ирсэн иргэдэд өдөр тутмын хяналтыг тавьж бүртгэн тусгаарлалтын хугацаа дуусахад ПГУ шинжилгээ авч ажиллаж байна.

Хүүхэд хамгааллын багаас олон нийтийн газраар бага насны хүүхдүүдийг олон нийтийн газраар явуулахгүй байх мөн хичээл сургалтын үйл ажиллагаа зогсоох хугацаанд гэртээ байхдаа эрсдэлд өртөхгүй байх талаар иргэд, эцэг эхчүүдэд зөвлөгөө өгөх, гэрээр явж үзлэг шалгалт хийх, цахимаар мэдээ, мэдээлэл өгөх ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

“Ковид-19” цар тахалтай холбоотойгоор халдвар бүртгэгдсэн сум, орон нутаг руу зорчихгүй байх, халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг баримтлах, маскаа байнга зүүхийг анхааруулсан урьдчилсан сэргийлэх зөвлөмж, зааврыг бэлтгэн Zuunbugenzag цахим хаягт сумын Шуурхай штабаас тогтмол байршуулан иргэдэд мэдээлэл хүргэн ажиллаж байна.

“Оролцоод хөгжье” сумын хүүхдийн цахим чуулганыг зохион байгуулж 48 сурагч оролцон 16 заалт бүхий уриалга гаргалаа.

2020-2021 оны хичээлийн жилд бүрэн дунд боловсролыг 23, суурь боловсролыг 48 суралцагч төгсөж, боловсролын баримт бичгээ гардан авлаа. 12 дугаар ангийн 18 төгсөгчдөд элсэлтийн ерөнхий шалгалт өгөх 7 төрлийн хичээлээр давтлага өгч байна.

1 дүгээр цэцэрлэг өөрийн хөрөнгөөр 6:4 хэмжээтэй туршилтын хүлэмж барьж 8 төрлийн хүнсний ногоо тариаллаа.

Засгийн газрын 2016 оны 153-р тогтоол “Сум хөгжүүлэх сан”-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 3.3.1 дэх заалтыг үндэслэн сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн тэргүүлэх чиглэлийг

1. Малын гаралтай түүхий эд боловсруулах жижиг үйлдвэрлэл
2. Ногоо болон жимсний жижиг үйлдвэр
3. Шатахуун түгээх станц
4. Зөгийн аж ахуй болон хүнсний ногооны зоорь барих
5. Барилгын материал үйлдвэрлэл
6. Алслагдсан багийн дугуй засвар
7. Авто машин засвар, угаалга, сэлбэг худалдаа
8. Зочид буудал зэргээр баталж зээлд хамрагдахаар хүсэлт ирүүлсэн 3 иргэний 27.0 сая төгрөгийн төслийг дэмжихээр шийдвэрлээд байна.

Сумын дүнгээр 10290 га-д үр тариа, 400 га-д тэжээл, 600 га-д тосны ургамал тариалах төлөвлөгөөтэйгөөс дараах байдлаар тариалалт хийгдээд байна.

Хөдөө аж ахуйг дэмжих сангаар дамжуулан “Ногоочдыг дэмжих зорилгоор 11 нэр төрлийн ногооны үрийг 90 гаруй ногоочдод 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олголоо.

Сумын эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран өрхийн тариалан эрхэлдэг эмэгтэйчүүдийг бүлгийн зохион байгуулалтад оруулж 5 бүлэгт 5 ширхэг хүлэмжийг 3 жилийн хугацаатай зээлээр олголоо.

2021 оны соёлолтыг иргэн, аж ахуйн нэгж бүрээр гаргахад сайн дүнтэй 10101 га талбай, дунд дүнтэй 260 га талбай байна.

Сумын Засаг даргын “Бог малд үзлэг ангилалт хийх тухай” А/59 тоот захирамжийн хүрээнд 12 өрхийн 2991 толгой бог малд үзлэг, ангилалт хийснээс хээлтэгч 20505, хээлтүүлэгч 386 толгой мал байна.

“Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн болзошгүй онцгой нөхцөл, гамшгийн хариу арга хэмжээ авах бүрэлдэхүүн хэсгийн эх үүсвэрээс мал аж ахуйн салбарын хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах үйл ажиллагаанд зарцуулах арга хэмжээний дагуу 2020 оны жилийн эцэст Үндэсний статистикийн хорооны А дансанд бүртгэлтэй малчин өрх бүрт 100,000 төгрөгийн дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд 300 малчин өрхийг бүрэн хамрууллаа.


Малын ашиг шим дээшлүүлэх зорилгоор махны чиглэлийн 4 ангус бухыг 4 малчин өрхөд 2 жил, “Газар агро” ХХК-аас авсан “Сэлэнгэ” үүлдрийн 5 бухан бярууг 5 өрхөд 3 жилийн хугацаанд ашиглуулах гэрээг тус тус байгууллаа.

Хаврын хуурайшилтын нөхцөл байдалтай уялдуулан сумын Засаг даргын 2021 оны “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/32 тоот захирамжийг хүрээнд ойн сан бүхий газарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдэд үүрэг чиглэл, иргэдэд сэрэмжлүүлэг, зөвлөмжийг хүргэн ажилласнаар ой хээрийн түймэр гараагүй байна.

Аймгийн хэмжээнд Ковид-19 цар тахлын дэгдэлт нэмэгдсэнтэй холбогдуулан Коронавирусээр халдварласан иргэдийг эмчлэх улаан, шар, ногоон 3 бүсийн 7 өрөөнд 18 ор бэлтгэлээ.

### **Мандал сум:**

Сумын Онцгой комиссын 2021 оны “Сумын Онцгой комиссын шийдвэр хэрэгжүүлэх тухай” 05 тогтоол, сумын Засаг даргын 2021 оны “Коронавируст /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай” А/134 тоот



захирамжийн хүрээнд 3 хоногийн хугацаанд сумын доторх хөдөлгөөн болон хүнсний худалдаа эрхлэгчдээс бусад худалдааны үйл ажиллагааг, 2021 оны 07 дугаар сарын 01-ийг хүртэл сумаас орох, гарах хөдөлгөөнийг түр зогсоон халдварын голомтыг цомхотгох ажил хийгдэж байна. Тус суманд Коронавируст /Ковид-19/ цар тахлыг илрүүлэх ПСР 25012, түргэвчилсэн 23539 нийт 48551 шинжилгээ хийгдэж 297 тохиолдол бүртгэгдсэн. Эдгээрээс 06 дугаар сарын байдлаар 151 нь эдгэрч, 144 иргэн аймгийн Ковидын тасаг болон Мандал сумын Ковидыг эмчлэх тасагт хэвтэн эмчлүүлж байгаа ба хэвтэн эмчлүүлж байгаа иргэдээс хөнгөн 143, хүндэвтэр 2, нас барсан 2 иргэн байна.

Нийт батлагдсан тохиолдлын 65,9 хувь буюу 196 хүн 6 дугаар сард бүртгэгдээд байна. Эдгээр иргэдийн 124 буюу 63,2 хувь Улаанбаатар хот болон халдвартай бус нутагт зорчсон, тухайн орон нутгаас гэрт нь хүн ирсэн иргэд байна.

Сумын Засаг даргын захирамж болон сумын Онцгой комиссын тогтоолоор суманд 144 ор бүхий 4 “Ковидыг эмчлэх тасаг” нээн ажиллуулж байгаа ба 6 сарын 25-ны өдрийн байдлаар 137 өвчтөн, 7 ойрын хавьтлыг хэвтүүлэн эмчилгээ хийж, 16 иргэнийг эмчилж гэрийн тусгаарлалтад шилжүүлсэн.

Коронавирус /Ковид-19/ цар тахлын эсрэг вакцины 1 дүгээр тунд 12463, 2 дугаар тунд 13276 иргэнийг хамруулан 25739 хүн тун вакциныг хийсэн. Ингэснээр сумын хэмжээнд бүрэн тунд хамрагдсан иргэдийн тоо 13352 болоод байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/171 тоот тушаалын дагуу 12 дугаар анги төгсөгчдөд 1 сарын хугацаанд танхимын давтлагыг халдвар хамгааллын дэглэмийг баримтлан, зохион байгууллаа.

Төрийн албан хаагчдын “Үндэсний бичиг”-ийн чадавхыг нэмэгдүүлэх, хэрэгцээ ач холбогдлыг таниулах зорилго бүхий “Үндэсний уйгаржин бичгийн хэрэглээ, ач холбогдол” сургалтыг зохион байгуулан 21 байгууллагын 101 албан хаагчийг хамруулсан.

“Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан сумын хүүхдийн элч Ч.Машбаттай хамтран бүтэн өнчин 20 хүүхдэд хүүхдийн баярын бэлэг, ЕБС-ийн 12 дугаар ангийн төгсөгч 3 хүүхдэд тус бүр 1 сая төгрөг хандивлалаа.

Цар тахлын үед “Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-т 2 иргэнийг тус бүр 4.0 сая төгрөгийн эргэн төлөлттэй хүүгүй зээлд, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т 1 иргэнийг 4.0 сая төгрөгийн 50 хувийн эргэн төлөлттэй зээлд хамрууллаа.

Сумын хэмжээнд 06 дугаар сарын байдлаар нийт 60305 хээлтэгч төллөхөөс 76.4 хувь буюу 42660 хээлтэгч төллөж 44528 төл бойжсон бөгөөд нийт төлийг төрлөөр нь авч үзвэл ботго 3, унага 3302, тугал 10888, хурга 13920, ишиг 16415 толгой байна.

Хагас жилд том малын зүй бус хорогдлоор 254 толгой буюу нийт малын 0.19 хувь хорогдсон байна. Үүнээс тэжээлийн дутагдал, арчилгаа маллагааны хорогдлоор 37.5 хувь, аюулт үзэгдлээр 51.3 хувь, халдваргүй өвчнөөр 11.2 хувийг эзэлж байна.

37 аж ахуйн нэгж байгууллага 2 иргэн 6300 га-д улаанбуудай, 1200 га-д ногоон тэжээл, 500 га-д тосны ургамал рапс тариалсан ба 26 аж ахуйн нэгж байгууллага 1200 өрхийн төмс хүнсний ногоо эрхлэгч 710 га-д төмс, 620 га-д хүнсний ногоо тариалсан байна.

06 дугаар сард нийт 4877 мал эмнэлгийн цахим гэрчилгээ бичигдэж, 237 толгой адуу, 377 үхэр, 1127 хонь, 557 ямаа, 35 гахай, тахиа 120, нийт амьдаар 2453 мал амьтан гарсан. Адууны мах 2031 кг, үхрийн мах 19743 кг, ямааны мах 643 кг, хонины

мах 8659 кг, тэмээний мах 280 кг, гахайн мах 215 кг, үхрийн сүү 133808 литр гарал үүслийн гэрчилгээ бичигдсэн.

Тус суманд бүтээн байгуулалтын ажлыг хуваарийн дагуу хийж эхлээд байна.

- “Хүүхэд залуучуудын соёл спортын цогцолбор төв”-ийн барилгын ажил 50 хувьтай үргэлжилж байна.
- Сумын Засаг даргын Тамгын газрын өрөө, танхимуудыг засварлах ажил хийгдэж байна
- 1 дүгээр багийн 45,43,36 дугаар байрны хойд талын автозамын тохижилтын ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.
- Зүүнхараа политехник коллежоос Спорт сургалтын цогцолбор төвийн уулзвар хүртэлх авто замд 1.1 км явган зам барих ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.
- Бохир усны насос станцын барилгын 6/04 кВ-ын 160 кВа дэд станцыг угсарч суурилуулж, хүчдэл авахад бэлэн болоод байна.
- Мандал сумын Түнхэл тосгоноос Төв аймгийн Батсүмбэр сум хүртэлх автозамын зураг төсөв боловсруулах ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж “Ар Си Эс Си” ХХК-тай гэрээ байгууллаа.

Талбай тусгаарлалт хийлгэх 4 аж ахуйн нэгж байгууллага хүсэлт гаргасны дагуу 3 аж ахуйн нэгж байгууллагад үйлдвэрлэлийн огтлолоор 8 га, цэвэрлэгээний огтлолоор 28 га нийт 36 га талбайд мод бэлтгэлийн талбай тусгаарлалтын ажил хийгдлээ. Хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичгийг 1 аж ахуйн нэгж байгууллагад 140 м3 хэрэглээ, 39 м3 түлээний эрхийн бичиг олгож, 13 нөхөрлөл, аж ахуй нэгж байгууллагад нийт 487 м3 хэрэглээ, түлээний модыг 32 гарал үүслийн гэрчилгээг тус тус олгосон.

Ойн хөнөөлт шавьжийн тандалт судалгааг ойн санг гэрээгээр эзэмшигч 9 аж ахуйн нэгж байгууллага “Улааншаварт”, “Бэр цагаан”, “Зүрхүзүү”, “Хүдэр”, “Ховооцой”, “Харчулуут”, “Үйсэн гэр”, “Хандгайт”, “Өвөргахайт”, “Хорилоогийн эх”, “Тайлж” гэх газрын 10928 га талбайд тандалт, судалгааны ажил явуулж хортон шавж илэрсэн 7101 га талбайд 3 аж ахуй нэгж байгууллага өөрийн хөрөнгөөр механик аргаар 1120 кг өндөг түүж тэмцлийн ажил явуулсан.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 17 дугаар тогтоолоор 229.1 га талбайд өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийхээр хуваарилсан бөгөөд 2 нөхөрлөл, 14 аж ахуйн нэгж байгууллагад 402250 ширхэг, 1-3 настай шинэс, нарсны тарьц, суулгацаар нийт 170,18 га талбайд ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

#### **Орхон сум:**

Сумын Засаг даргын 2021 оны “Хязгаарлалтын дэглэм тогтоох зарим үйл ажиллагааг түр хориглох тухай” А/80 тоот захирамжийн хүрээнд 2021 оны 06-р сарын 18-21 өдрийн хооронд хязгаарлалт тогтоон төрийн байгууллагууд болон нэр заагдсан хувийн байгууллагууд цагийн хязгаарлалттай ажилласан. Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх” А/15 захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 18 ААН, байгууллагын давхардсан тоогоор 12810 м<sup>2</sup> талбайд халдваргүйжүүлэлт хийгдсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд [www.operator.e-mongolia.mn](http://www.operator.e-mongolia.mn) үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан нийт 42 иргэнд 11 төрлийн цахим лавлагааг хурууны хээг үндэслэн олгосон байна.

Сумын Засаг даргын 2021 оны “Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх тухай” А/81 тоот захирамжийн хэрэгжилтийн хангах ажлын хүрээнд сэрэмжлүүлэг мэдээг 36 айл өрхөд хүргэж ажиллалаа.

КОВИД-19 цар тахалтай холбоотой зөвлөмж, анхааруулга, улс, аймаг, сумын онцгой комиссын шийдвэр, мэдээ мэдээллийг шторк хэлбэрээр хүргэх ажлыг сумын ФВ хаягуудыг ашиглан иргэдэд цаг хугацаанд нь мэдээ мэдээлэл хүргэж ажилласан бөгөөд давхардсан тоогоор 352 иргэний тандалтыг авсан байна.

Байнгын 24 цагийн постыг Бэлэндалай өртөөний гарман дээр байрлуулан, хөдөлгөөнд хяналт тавьж тус хяналтын постыг хариуцан ажиллаж байна. Хяналтын цэгт ЗДТГазар, төр төсвийн байгууллагын албан хаагч, хэсгийн төлөөлөгч, цагдаа, гал унтраах 61-р ангийн алба хаагч, нийт 19 албан хаагч ажиллаж байна.

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ДЗОУБ, ЗДТГазар хамтран “Хүүхэд хамгааллын 5 хурууны дүрэм”, “Хүүхэд бүхэн эрхтэй”, “Миний гэр бүлийн аз жаргал” цахим уралдаанд 63 сурагч оролцлоо.

2021 онд 43131 толгой хээлтэгч эх мал төллөхөөс гүү 1151, үнээ 3794, эм хонь 15574, эм ямаа 15750 бүгд 36269 толгой эх мал төллөж, төллөлтийн хувь нь 84.1 хувьтай байна. Нийт 36384 толгой төл хүлээн авч төл бойжилт 99,7 хувьтай байна.

Сумын хэмжээнд үр тариа 9196 га, тэжээлийн ургамал 1274 га, тосны ургамал 2842 га, төмс 370 га, хүнсний ногоо 263 га талбайд тус тус тариалалт хийсэн. Сэлэнгэ аймгийн ХХААГ-аас хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон 700.000 төгрөгийн хүлэмжид 4 өрх хамрагдлаа. ХХААХУЯ-аас өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжих зорилгоор 80 хувийн хөнгөлөлттэй олгосон хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд өрхийн тариалан эрхэлдэг нийт 40 иргэнд ногооны үрийг хувиарлан өгч ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/101 тоот, сумын Засаг даргын 2021 оны А/69 тоот “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах захирамж”-ийн хүрээнд Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад Бүрэн-Орхон ХХК 72000 үхэр, 10000 бог Эгдэм БГБХН 7400 үхэр, 13000 бог малд тарилга хийгдлээ Мөн цусан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад Эгдэм БГБХН 2200 үхэрт, Бүрэн-Орхон ХХК 1200 үхэрт тарилга хийгдлээ. Сахуу өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга 440 унагат хийгдсэн. Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлын хүрээнд МЭҮН-д 178 малчин мал бүхий өрхийн 72844 мкв малын хашаа хороо, 3 худаг уст цэгийн, 82 мкв талбай 2 устгалын цэгийн 152 мкв талбайд хайкоп ариутгалын бодисоор шүршиж халдваргүйжүүлэлт хийгдлээ.

Орон нутгийн байгууллагуудын төсвийн санхүүжилтийн зарцуулалтын гүйлгээг батлагдсан төсвийн дагуу анхан шатны баримтыг үндэслэн 197,834,246.22 төгрөгийн гүйлгээ хийгдлээ.

### **Орхонтуул сум:**

Суманд 2021 оны 06 дугаар сарын 13нд /Ковид-19/-ын сэжигтэй тохиолдол илэрч шинжилгээ батлагдсан тул сумын хэмжээнд хязгаарлалт тогтоон сумын онцгой комиссоос шуурхай арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Тандалтын баг байгуулж баг бүрэлдэхүүн тандалт судалгаа маршрут гарган нийт хавьтлуудыг тодорхойлон тусгаарлалт ажиглалтад авч ажиллалаа.

2021оны 06 дугаар сарын 15-нд "Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлт"-ийн ажлыг нийт төр төсвийн байгууллага, аж ахуй нэгж, худалдаа үйлчилгээний газрууд, хүүхдийн тоглоомын талбай, орц хонгилууд, нийтийн эзэмшлийн талбай зэрэг нийт 7489,9м2 талбайд мананцар үүсгэх төхөөрөмжөөр хийж гүйцэтгэлээ. Аж ахуй нэгж байгууллагууд, төр төсвийн байгууллагууд, худалдаа үйлчилгээний байгууллага тус бүр

2 цаг тутамд ариутгалыг хийлгэж хяналт тавин ажиллаж байна. Цаг үеийн нөхцөл байдлын талаар Засгийн газар, Аймгийн Засаг дарга, Улс аймгийн Онцгой комисс, Эрүүл мэндийн байгууллагуудаас гаргасан заавар, зөвлөмж, шийдвэрүүдийг тухай бүр иргэдэд цахимаар болон шуурхай штабын утсаар мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Эрх зүйн хөтчийн булангаар үйлчлүүлж байгаа иргэдэд Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, санал өргөдөл гомдлын тухай хууль, зөрчлийн тухай хуулиар мэдээлэл бэлтгэн гарын авлага тараан Орхонтуул сумын ЗДТГ, Рашаант тосгоны захирагчийн албаны фэйсбүүк хуудсанд байршуулсан.

Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр Хүүхэд хөгжлийн төвтэй хамтран хүүхэд багачуудын авъяас чадварыг дэмжин хөгжүүлж, хүүхдүүдийн идэвх санаачлага, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Оролцоод хөгжье” цахим арга хэмжээнд Орхонтуул сумын 20 хүүхэд хамрагдлаа.

Улсын хэмжээнд хагас жилийн мал тооллого явагдаж багийн засаг дарга нартай хамтран тооллогын ажлыг 100% гүйцэтгэж дуусгаж ажиллалаа.

### **Сайхан сум:**

Сумын Онцгой комиссын бүрэлдэхүүн, Шуурхай штабыг 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдөр шинэчлэн байгуулж, захирамж шийдвэрээр албажуулсан.

Сумын хэмжээнд Коронавируст халдвар /Covid-19/-ын цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 18:00 цагаас эхлэн 2021 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 00:00 цаг хүртэл 10 хоногийн хугацаанд хөл хорио тогтоож ажиллалаа.

Хязгаарлалт тогтоосон хугацаанд бүх төрлийн хүнсний дэлгүүр, эмийн санг өглөө 10:00 цагаас оройн 20:00 цаг хүртэл ажиллуулахаар тогтоосон бөгөөд 2021 оны 06 дугаар сарын 25-наас 06 дугаар сарын 27-ны өдрийн хүртэл хугацаанд төр төсвийн 7 байгууллагын 20 эрэгтэй, 5 эмэгтэй албан хаагчийг үүрэгжүүлэн иргэдэд хяналт тавьж, гадуур эргүүлээр ажиллуулсан.

Коронавирус /Covid-19/-ын эсрэг дархлаажуулалтад сонгогдсон зорилтот бүлгийн 144 хүнийг АНУ-ын Файзер вакцинд хамрууллаа. Халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 7 хүний бүрэлдэхүүнтэй баг амжилттай зохион байгуулсан. Дархлаажуулалттай холбоотой урвал хүндрэл гараагүй байна.

Сум дундын Цагдаагийн хэлтэстэй хамтран төлөвлөгөөт хяналт шалгалтыг 1, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 1 удаа тус тус зохион байгуулж ажилласан. Хяналт шалгалтын хүрээнд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй газрын хэвлийн ашигласан 1 иргэнд “Зөрчлийн тухай хууль”-аар 150.0 төгрөгийн торгууль шийтгэлийн арга хэмжээ авч ажилласан. Хууль бус мод бэлтгэсэн 1 иргэнд сум дундын Цагдаагийн хэлтсээс эрүүгийн хэрэг нээн шалгаж байгаа хэрэгт шинжээчээр ажиллаж Ойн санд учруулсан 680.0 төгрөгийн хохирол нөхөн төлбөр тооцсон Улсын байцаагчийн дүгнэлт гаргасан.

Газар тариалангийн чиглэлээр нийт 26378,5 га эргэлтийн талбайтай үүнээс 2021 онд үр тариа 13257,8 га-д, төмс 250 га-д, хүнсний ногоо 170 га-д тариалалт хийлээ. Сумын хэмжээнд 11820 га талбайд уринш хийж иргэн, аж ахуйн нэгж байгууллага 778 тн үрийн будаа нөөцөлсөн ба дутагдалтай 873 тн үрийн будааг “Хөдөө аж ахуйг дэмжих сан”-аас иргэн, ААНБ урьдчилгаа төлөлттэй зээлийн гэрээгээр авсан байна. ХААДС-аас авсан улаанбуудай үрийн 79,6 хувь буюу 615 тн элит үр, 20,4 хувь ба 258 тн дотоод үр байна.

Сум хөгжүүлэх сангийн сонгон шалгаруулалтын орон тооны бус зөвлөл хуралдаж нийт 20 төслийг хэлэлцэн 10 төслийг журамд тусгагдсан шаардлагын дагуу хэлэлцэн баталж 95.0 сая төгрөгийг сангийн хөрөнгөөс гарахаар шийдвэрлэгдсэн.

Хорио цээрийн дэглэмийн үед аж ахуйн нэгж байгууллагуудаар тогтмол өдөр тутмын ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэж эрсдэл өндөртэй 15 байгууллагын хяналт тавин бүртгэл хөтөлж, нийтийн эзэмшлийн зам, гудамж талбайн 147.327 м<sup>2</sup>, тоглоомын талбай, байрны орц, хогийн сав зэрэг 91 объектийн 13.650 м<sup>2</sup>, аж ахуй нэгж байгууллагын 32096 м<sup>2</sup> талбайн нийт 199.323 м<sup>2</sup> талбайг ариутган иргэдийн ахуйн ариун цэвэр сайтар сахин ариутгал халдваргүйтгэл хийхийг уриалан ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсвийн байгууллагуудыг тоолууржуулах тухай” 144-р тогтоолын хэрэгжилтийг түргэвчлүүлэх арга хэмжээ авч, сумын хэмжээнд нийт 18 байгууллагын төсвийн захирагч нарт танилцуулан, өөрийн байгууллагад тохирох тоолуурыг сонгох, худалдан авахад бэлтгэх ажлыг зохион байгуулан ажилласан.

Суманд үүсээд буй нөхцөл байдлаас шалтгаалж эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх иргэдийн үзлэгийг Хөтөл Ерөнхий боловсролын 1-р сургуульд байрлуулан ажиллуулж байгаатай холбогдуулан төгсөх ангийн сурагчдын танхимын давтлагыг цахим хэлбэрт шилжүүлэн чанартай зохион байгуулан ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт даалгаад байна.

Коронавируст халдварын шинж тэмдэг илэрсэн болон батлагдсан тохиолдлыг аймгийн Онцгой комисст шуурхай мэдэгдэж мэргэжил, арга зүйн зөвлөгөөг тухай бүр авч ажиллаж байна.

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Ж.Од, аймгийн Засаг даргын Орлогч Ц.Рэгзэдмаа нараар ахлуулсан ажлын хэсэг Зоонозын өвчин судлалын төв, Мэргэжлийн хяналтын газартай хамтран Ковидын тасгийг Хөтөл Эрүүл мэндийн төвд байгууллаа.

#### **Сант сум:**

Сумын хэмжээнд 7 аж ахуй нэгж, 100 гаруй иргэн 2228,6 га талбайд улаан буудай, 18 га талбайд овьёос, 1958,2 га талбайд тосны ургамал, 7 га-д эмгийн ургамал, 696.7 га талбайд ногоон тэжээл, 200 га-д төмс, 142,2 га талбайд хүнсний ногоо тариалаад байна.

Хүнс хөдөө аж ахуйн яамнаас хаврын тариалалтад дэмжлэг үзүүлэн сумын иргэдэд хүлэмж болон хүнсний ногооны үрийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олголоо. Хөнгөлөлттэй нөхцөлөөр 4 иргэнд 2.400.000 төгрөгийн үнэ бүхий 4 ширхэг хүлэмж, 46 иргэнд 3.190.625 төгрөгийн үнэ бүхий 8 төрлийн хүнсний ногооны 1158,6 кг үрийг олгосон байна.

Сумын Засаг даргын 2021 оны “Малын хагас жилийн түүвэр судалгааг явуулах тухай” А/71 тоот захирамжаар ажлын хэсэг томилогдон 2021оны 06 дугаар сарын 15-22 өдрүүдийн хооронд хагас жилийн мал тооллогын ажил явагдаж дууслаа. Сумын хэмжээнд түүвэр судалгаанд 63 өрх 1 аж ахуйн нэгжийн 27143 мал тоологдож 2 чиглэлд 5 тоологч ажилласан байна.

Улсын хэмжээнд зарлагдсан “Бүртгэлжүүлэлтийн аян”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ээмэгний захиалга авах зорилгоор үхэртэй өрхийн судалгаа хийгдлээ. Сумын хэмжээнд 378 малчин, мал бүхий өрхийн 12738 үхэр байгаагийн 135 бух, 5258 нь хээлтэгч байгаа бөгөөд энэ оны төлийг нэмээд 18026 үхэр ээмэглэхээр байна. Ээмэгний захиалга авч эхлээд байна.

Бог малын хээлтүүлэгчид хяналтын самналт хийх заавар, зөвлөмж өгч ухнын хаврын жингийн үзлэг, ноолуурын хяналтын самналтын ажлыг хийлээ. Үзлэгт нийт 186 ухна хамрагдаж ноолуурын дундаж гарц 361 гр, хаврын амьдын жин 44,8 кг байна. 71 ухна ноолуурын гарц, 22 ухна амьдын жингийн үзүүлэлтээр үржлийн хээлтүүлэгчийн стандарт шаардлага хангахгүй нь тогтоогдлоо.

Бухны хүрэлцээ хангамжийн судалгааны дүнгээр сумын хэмжээнд 210 бухтай байхаас 135 бух байгаа нь 75 бух дутагдалтай, хүрэлцээ хангамж 64 хувьтай байна. Аймгийн ХААГ-аас сумдыг хээлтүүлэгчээр хангах бодлогын хүрээнд таван өсвөр бух нийлүүлснийг КЦТ үүлдрийн үхэр өсгөн, хээлтүүлэгч бойжуулах боломж бүхий малчин өрхүүдэд хуваарилан гэрээ хийж ажиллалаа.

2021 оны 06 дугаар сарын 15-ны өдөр "Дэлхийн Зөн Монгол" олон улсын байгууллагын Сэлэнгэ Нэгдсэн хөтөлбөрийн багш ажилтнууд Сант суманд ажиллан "Хүүхдийн сайн сайхны төлөө зөвлөл"-ийг хуралдуулж 2021-2022 онд хамтран ажиллах ажлын төлөвлөгөөг хэлэлцлээ. "Төгсөлтийн аргачлал" арга хэмжээнд хамрагдаж байгаа 20 өрхийн гишүүдэд "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга" сургалтыг зохион байгууллаа.

2021 оны 06 дугаар сарын 21-ний өдөр сумын хэмжээнд "КОВИД-19" халдварын тохиолдол илэрсэнтэй холбоотойгоор Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Ж.Од ахалсан Зооноз өвчин судлалын төвийн мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг суманд 2 өдөр ажиллаж сумын Онцгой комисс, ЭМТ, Шуурхай штабын бүрэлдэхүүнд цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгааг газар дээр нь өглөө. Сумын хэмжээнд нийт 899 хүнийг өргөтгөсөн шинжилгээнд хамруулснаас түргэвчилсэн оношлуураар 15 сэжигтэй тохиолдол илэрсэн байна. Эдгээр сэжигтэй тохиолдлын ойрын хавьтал болох 56 хүнээс PCR-ийн шинжилгээ авч аймагт хүргүүлснээс батлагдсан тохиолдол 19 болсон байна.

Сумын Онцгой комиссын 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны шийдвэрээр сумын хэмжээнд хөл хорио, хязгаарлалтын дэглэм тогтоож ШТС, эмийн сангаас бусад худалдаа үйлчилгээний газруудын үйл ажиллагааг түр хугацаагаар хязгаарлаж, өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүнийг иргэдэд хүргэлтээр хүргэж үйлчилсэн.

2021 оны 06 дугаар сарын 27-ны өдөр сумын хэмжээнд 12-17 насны хүүхдүүд, хөхүүл болон жирэмсэн эхчүүд, архаг хууч өвчний заалттай иргэдийг вакцинд хамруулах эхний ээлжийн дархлаажуулалтын ажил явагдаж 135 хүүхэд, 15 том хүн хамрагдсан байна.

#### **Сүхбаатар сум:**

Сумын шуурхай штаб тухай бүр хуралдан УОК, АОК, СОК-оос гарсан шийдвэрүүдийг тухай бүр олон нийтэд сурталчилан иргэдэд хүргэх, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Сүхбаатар суманд Коронавируст халдвар /Ковид-19/-ын батлагдсан тохиолдлын тоо эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 2021 оны 06 дугаар сарын 18-21 өдрүүдийн хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад орох хөдөлгөөнийг хориглолоо. Хязгаарлалтын хугацаанд 18 градусаас дээш согтууруулах ундааг 12:00-18:00 цагийн хооронд худалдан борлуулах, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан ажиллуулах талаар хяналт тавин ажиллалаа.

Сумын Засаг даргын Б/16 тоот захирамжаар Коронавируст халдвар /Ковид-19/-ын батлагдсан болон сэжигтэй цогцсыг оршуулахад хяналт тавих, мэргэжил арга зүйн



зөвлөгөө, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шуурхай бүлгийг байгуулж тухай бүр ариутгал халдваргүйтгэлийг хийж байна.

Тус сард голомттой бүсээс ирсэн 227 иргэн гэрийн тусгаарлалтад орж ойрын хавьтлын 646 иргэн нийт 811 иргэнээс шинжилгээ авсан байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор халдвар бүртгэгдсэн сум, орон нутаг руу зорчихгүй байх, халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг баримтлах, маскаа байнга зүүхийг анхааруулсан урьдчилсан сэргийлэх зөвлөмж, зааврыг бэлтгэн цахим хаягт байршуулан иргэдэд сурталчлан ажиллаж байна.

Салхит 3-р багийн шинэ цэцэрлэгийн барилгын ажил дууссан ба улсын комисс хүлээн аваагүй байна. Ажлын гүйцэтгэлд хяналт тавих чиглэлтэй түр хүн томилж ажиллуулсан.

Сумын хэмжээнд соёлын биет болон биет бус өвийг тээгч хадгалагч өвлөн уламжлуулагчийн шинэчилсэн бүртгэл хийж баг бүрт өвийн судалгаа явуулан шинээр бүртгэгдсэн өвийг цахим баримтжуулах ажлыг 2021 оны эхний хагаст хийсэн. Бүртгэлээр шинээр биет 2 өв бүртгэгдэж, биет бус өвлөн тээгчийн цахим бичлэгийг хийж баримтжуулж байна.

Хүүхдийн оролцоог дэмжих “Оролцоод хөгжье” цахим чуулган зохион байгуулж 112 хүүхэд оролцлоо.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 1-р цэцэрлэгийн хашаанд хүүхдийн тоглоомын талбай нэмэгдүүлэх тохижуулах ажлын үнийн саналыг Сэлэнгэ таван хан, Хүчит Сэлэнгэ, Сэлэнгэ ундрам ХХК-уудад хүргүүлсэн. Үнийн саналыг ирүүлсэн Сэлэнгэ таван хан ХХК-тай 1-р цэцэрлэгийн хашаанд хүүхдийн тоглоомын талбай нэмэгдүүлэх тохижуулах ажлын шууд гэрээг хийж ажиллалаа.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгө оруулалтад тусгагдсан "Сүхбаатар суманд багийн болон өрхийн эмнэлгийн байр барих" ажлыг "Содон сод оюу" ХХК гүйцэтгэн 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдөр улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад шилжүүлэхээр боллоо.

“Дэд бүтэц” төслийн хүрээнд Австри улсын Засгийн газрын хөрөнгөөр хийгдэж байгаа гэрэлтүүлгийн ажилд ГХБХБГ-ын мэргэжилтнүүдтэй хамтарч хяналтыг хийж байна

Аймгийн Онцгой комиссын 2021 оны 06-р сарын 02-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 5720 тоот, 6-р сарын 10-ны өдрийн 5745 тоот, 06-р сарын 11-ны өдрийн 5751 тоот, 6-р сарын 13-ны өдрийн 5754 тоот албан бичгүүдийн хүрээнд хүрээнд бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажилд 06 дугаар сард мэргэжилтний хамт хяналт тавин ажиллалаа. Энэ хугацаанд хүнсний чиглэлийн 44 объектын 5200 м2 талбай, хүнсний бус нийтийн эзэмшлийн 7 объектын 5100 м2 талбайд ариутган халдваргүйжүүлэлт хийсэн байна.

Онцгой байдлын газрын 31/201 дугаартай үер усны аюулаас урьдчилан сэргийлэх талаар хийсэн ажлын тайланг цахим хаягаар нь хүргүүллээ. Гол мөрөн нуурын арал ,тохой ,эрэг дагууд болон уулын ам, бэл, гуу жалга, судгийн аманд байгаа 1,5-р багийн 8 өрхөд анхааруулга өгч 5 айлыг 1-р багийн Засаг дарга хариуцан нүүлгэн шилжүүлсэн.

Хагас жилийн малын түүвэр судалгааг сумын хэмжээнд 45 өрх, 1 аж ахуй нэгж байгууллагын мал тоолж нийт 45 өрхийн адуу-180, үхэр-826, хонь-1342, ямаа-2329 нийт 4677, 1 ААНБ-ын адуу-828, үхэр-331, хонь-1184, ямаа-889 нийт 3232 мал буюу нийт 7909 мал тоолсон.

### **Түшиг сум:**

Коронавируст халдвар дахин гарсантай холбоотойгоор сумын Засаг даргын 06 дугаар сарын 12-ны өдрийн “ Хөдөлгөөнийг хязгаарлах тухай” А/54 дугаар захирамжаар сумын гарах болон орох хөдөлгөөнийг 72 цагийн хугацаатай хязгаарласан ба шуурхай штаб, хяналтын постон дээр 24 цагаар ажиллаж байна. Мөн Засгийн газрын тогтоол, УОК-ын шийдвэр, АОК-ын шийдвэрийг сумын ЗДТГ-ын албан ёсны групп дээр тогтмол байршуулан, хууль тогтоомж болон сургалт сурталчилгааг байршуулан ажиллаж байна.

Үр тариа 9415 га-д тариалалт хийснээс: Улаанбуудай 8229 га, овьёос 511 га, тэжээлийн ургамал 179 га, үүнээс рапс 3045 га нийт 12639 га-д тус тус тариалалт хийгдсэн байна. Төмс, хүнсний ногооны тариалалтад:Төмс-17 га, нийт 12639 га-д тус тус тариалалт хийсэн.

2 дугаар багийн нутаг дэвсгэрт орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 1 шинэ тоглоомын талбай шинээр ашиглалтад оруулж, хүлээлгэн өгөхөд бэлэн болоод байна.

### **Хушаат сум:**

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор [www.e-mongolia.mn](http://www.e-mongolia.mn) төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн системээр энэ сард 38 иргэнд хурууны хээг үндэслэн цахим лавлагааг гаргаж үйлчилсэн.

Ариутгал халдваргүйжүүлэлтийг төр төсвийн 5 байгууллагад 7347м<sup>2</sup>, хүнс худалдаа үйлчилгээний байгууллагад 1144м<sup>2</sup>, үйлчилгээний ШТС, банкинд 872м<sup>2</sup>, нийтийн эзэмшлийн тоглоомын талбайд 4000м<sup>2</sup>, нийт13463м<sup>2</sup> талбайд хийж гүйцэтгэлээ.

Хүүхдийг болзошгүй эрсдлээс хамгаалах зорилгоор эцэг эхчүүдэд зориулан хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, хүүхдийн тусламжийн 108 утас, хүүхэд хамгаалал, ковид-19 цар тахалтай холбоотой видео, шторкыг сумынхаа цахим хаягаар 5 удаа олон нийтэд түгээж мэдээллээр хангаж ажиллалаа.

### **Хүдэр сум:**

2021 оны хагас жилийн байдлаар төллөвөл зохих 16410 толгой мал төллөхөөс 12403 толгой мал төллөж сумын хэмжээний мал төллөлт 66,6%-тай байна. Сумын хэмжээний том малын хорогдол нийт 244 толгой байна. Үүнээс Адуу-14, Үхэр-30, Хонь-110, Ямаа-90 байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 06-р сарын 10-ны өдрийн А/188 тоот захирамжийн дагуу 06-р сарын 15-наас 06-р сарын 20 хүртэл хугацаанд Хагас жилийн малын түүвэр тооллогын ажлыг сумын орлогч даргаар ахлуулан 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан 4 хэсэгт хуваагдаж 1 ААНэгж, 17 малчин өрх, 39 мал бүхий иргэдэд тооллогыг явуулж бүртгэлийн программд шивэлт хийсэн.

2021 онд 6 аж ахуй нэгж, 84 иргэн нийт 7225 га талбайд үр тариа, 69 га талбайд төмс, 46 га талбайд хүнсний ногоо тариалаад байна.

“Шинэ Хөдөө” төсөл хөтөлбөрийн хүрээнд Сумын 4 иргэнд 4\*8 хэмжээтэй хүлэмжийг 1 ширхэг 700,000 төгрөг 50 % хөнгөлөлттэйгөөр олгосон.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд ААН байгууллагын хашааг засаж, сэлбэн амьдрах чадваргүй модыг авч нөхөн тарилт хийж суманд үйл ажиллагаа явуулдаг 17 ойн мэргэжлийн байгууллага, 6 албан байгууллага нийт 48 ширхэг нас модыг шилжүүлэн суулгасан байна. Мөн Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор мод шилжүүлэн суулгах эрхтэй 3

аж ахуй нэгж, Засан дарга, Ойн ангитай нийт 210 ширхэг нарс мод шилжүүлэн суулгах гэрээ байгуулан ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургууль, ЗДТГазар, “Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллага хамтран 8-11 ангийн төлөөлөл болох 35 сурагчдын дунд “Оролцоод хөгжье” цахим хүүхдийн чуулга уулзалтыг зохион байгуулсан.

#### **Цагааннуур сум:**

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Нэгдүгээрт хүүхэд” цахим аяныг өрнүүлж уг ажлын хүрээнд Цагааннуур-Нэгдүгээрт хүүхэд цахим хаягийг нээж хүүхэд хамгаалал, хөгжил, хүмүүжлийн талаар мэдээлэл, зөвлөж 8 төрлийн контентийг иргэдэд үе шаттайгаар хүргэж ажиллаа.

Сумын Засаг даргын 2021 оны А/61 тоот захирамжийн дагуу малын хагас жилийн түүвэр тооллогыг 15-22-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тооллогод нийт 113 өрх 7 аж ахуйн нэгжийн 62608 толгой мал тоолуулсан. Үүнээс: адуу-1415, үхэр-12222, хонь-29131, ямаа-19840 толгой байна.

Цар тахал нэмэгдэж байгаатай холбогдуулан сумын Онцгой комиссын шийдвэрээр 2021 оны 06 дугаар сарын 17-22-ны өдрүүдэд сумын орох гарах хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон.

Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг чиглэлийн 120.8 км хатуу хучилттай автозамын ажил эхэлсэн.

2021 оны мал, амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 55400 толгой хурга, ишиг хамруулахаас 54200 толгой төл хамруулсан. Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 25800 толгой бод хамруулахаас 16480 толгой бод, цусан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 5600 толгой бод хамруулахаас 3960 үхэр хамруулсан байна.

#### **Шаамар сум:**

Монгол Улсын Засгийн газрын 105 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны “Түр журам батлах тухай” 46 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2021 оны 17 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн эрчимжүүлэх” А/15 тоот захирамжийн хүрээнд Шаамар сум Дулаанхаан тосгоны төр төсвийн нийт 32, худалдаа үйлчилгээний 18 байгууллагын нийт 21586,2 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажилласан. Мөн 4-н замын пост, Ковидын тасаг байгуулагдсантай холбогдуулан сумын Эрүүл мэндийн төв болон Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийг 2 цаг тутамд ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэн ажиллаж байна.

Сумын хэмжээнд эргүүл хяналтыг 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр, шуурхай штабыг 24 цагаар тус тус ажиллуулж байна. Сумын хэмжээнд Улаанбаатар хотоос 1 тээврийн хэрэгсэлтэй, эрсдэл бүхий сумаас ирсэн 1 тээврийн хэрэгсэлтэй, том хүн 8 хүүхэд 7 хүнийг халдвар хамгааллын дэглэмийг баримтлан бүртгэлжүүлж нийт 8 өрхийн 8 том хүн, 7 хүүхэд, хамт байгаа өрхийн гишүүдийн тоо 14, нийт 29 хүнийг гэрийн ажиглалтад аваад байна.

2021 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Шаамар сумын иргэн 34-р км оршин суух 8 настай иргэн Н, В нар нь Сүхбаатар суманд айлд очиж хоносон. Уг айлаас коронавирус илэрсний дагуу дээрх 2 иргэнээс PCR-ийн шинжилгээ авахад охин Н-ын хариу эерэг гарсантай холбогдуулан уг хүүхэдтэй хамт тоглосон 2 өрхийн 4 том хүн 6 хүүхдийг

гэрийн тусгаарлалтад оруулсан. Мөн 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдөр Улаанбаатар хотоос ирсэн иргэн М-ийн шинжилгээний хариу эерэг гарсантай тул ойрын хавьтал болох 1 өрхийн 2 том хүн 3 хүүхдийн хамт гэрийн тусгаарлалтад авсан.

Аймгийн хэмжээнд “Коронавирусын халдвар /Ковид-19/-ын батлагдсан болон сэжигтэй цогцсыг оршуулах үйл ажиллагаанд мөрдөх түр журам”-ын дагуу сумын Засаг даргын А/93 захирамжийн дагуу ажлын хэсгийг томилгоожууллаа.

2021 оны 06 сарын 12-ны өдөр Онцгой байдлын ерөнхий газрын аврах баг, шуурхай бүлэгтэй хамтран үерт автсан 3 айлыг нүүлгэн шилжүүлэг хийсэн. Багийн Засаг дарга нар, Байгаль хамгаалагч, мал зүйч нар хамтран алслагдсан малчдад утсаар болон биеэр очиж сэрэмжлүүлгийг хүргэж урьдчилан сэргийлж ажилласан байна. Шаамар сумын ЗДТГ, Шаамарынхан, Дулаанхаан сайхан нутаг, Бид Шаамарынхан зэрэг цахим хаягууд дээр цаг уур, орчны мэдээллийг хүргэж, үерт автсан нийт 23 айл өрхийг сэрэмжлүүлгийг цахимаар болон чанга яригчаар иргэдэд 6-н удаа хүргэж ажилласан боловч айл өрхүүд үерийн эрсдэлтэй газраас нүүж шилжээгүйн улмаас үерийн усанд өртсөн болно. Гамшгаас хамгаалах эрэн хайх шуурхай бүлэгтэй хамтран сумын аврах бүлэг 3 өрхийг үерийн уснаас гаргаж ажилласан.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын малын хүүр сэг зэм устгах захирамжийн хүрээнд үхэр-12, адуу-5, хонь-24, ямаа-27 толгой малыг устгаж ариутгал халдваргүйтгэлийг хийж ажилласан.

**ХЯНАСАН:**

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН**

**ГАЗРЫН ДАРГА**

**Ө.СУВДАА**

**НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:**

**МЭРГЭЖИЛТЭН**

**Э.БАНЗРАГЧГАРАВ**